



Шинжээчийн тайлан

Байгууллагын нэр: МУИС, Хэрэглээний шинжлэх ухаан инженерчлэлийн сургууль

Хөтөлбөрийн нэр: “Ойн аж ахуй” хөтөлбөр

Индекс: D082101

Шинжээчийн баг:

Ахлагч: Д.Хандсүрэн

Гишүүд: О.Энхтуяа

Я.Гэрэлчулуун

Агуулга

Товчилсон үгийн тайлбар

I. Хөндлөнгийн үнэлгээ хийх үйл явц, төлөвлөлт

II. Сургалтын хөтөлбөрийн танилцуулга

III. Шинжээчийн үнэлгээ, дүгнэлт

Шалгуур1: Хөтөлбөрийн төлөвлөлт

Шалгуур 2: Сургалтын үйл ажиллагаа

Шалгуур 3: Хөтөлбөр хэрэгжүүлэх орчин, технологийн нөхцөл

Шалгуур 4: Хөтөлбөрийн удирдлага, зохион байгуулалт

Шалгуур 5: Суралцагчид чиглэсэн үйл ажиллагаа

Шалгуур 6: Багшийн үйл ажиллагаа

Шалгуур 7: Чанарын үнэлгээ, баталгаажилт

IV. Уулзалтад оролцогчдын нэрс

I. Багш нарын нэрс

II. Оюутнуудын нэрс

III. Ажил олгогчдын нэрс.

IV. Төгсөгчдийн нэрс

V. Хөтөлбөрийн өөрийн үнэлгээний багаас ирсэн санал

VI. Мэргэжлийн зөвлөлийн шийдвэр

VII. Магадлан итгэмжлэх комиссын шийдвэр

I. Хөндлөнгийн үнэлгээ хийх үйл явц, төлөвлөлт

Сургуулийн нэр /Монгол, Англи/	Монгол Улсын Их Сургууль National University of Mongolia	
Сургалтын хөтөлбөрийн нэр /Монгол, Англи/	“Ойн аж ахуй” бакалаврын хөтөлбөр “Forestry” bachelor's program	
Индекс	D082101	
Шинжээчил БМИУЗ-ийн Мэргэжилтэн	1. Д.Хандсүрэн, ХААИС, АЭС-ийн Таримал судлал, Ой, Ландшафтын Архитектурын тэнхимийн эрхлэгч, доктор, дэд профессор 2. О.Энхтуяа, Шинжлэх ухааны академийн Ботаникийн цэцэрлэгт хүрээлэнгийн Ургамлын ангилал зүй филогенетикийн лабораторийн эрдэм шинжилгээний тэргүүлэх ажилтан, доктор 3. Я.Гэрэлчулуун Монгол улсын боловсролын их сургуулийн Ургамлын судалгаа, сургалт арга зүйн төвийн эрхлэгч, доктор	
Төлөвлөгөө	Он сар өдөр	Хийгдсэн байх ажлууд /Мэргэжилтний гаргаж өгсөн хуваарийн дагуу бичнэ/
	2021.11.16	Шинжээчийн багийг томилох
	2021.11.17	Мэргэжилтэн шинжээчдийн багаас ашиг сонирхлын зөрчилтэй эсэх талаар саналыг хүлээн авах
	2021.11.19	Шинжээчидтэй гэрээ байгуулах
	2021.11.19	Шинжээчдэд өөрийн үнэлгээний тайланг хүлээлгэн өгнө.
	2021.11.25	Шинжээчид урьдчилсан үнэлгээний тайланг мэргэжилтэнд хүлээлгэн өгнө.
	2021.11.29	Мэргэжилтэн сургууль дээр очиж шинжээч ажиллах бэлтгэлийг хангуулна.
	2021.11.30 2021.12.01.	Сургууль дээр очиж шинжээчид ажиллана.
	2021.12.09	Шинжээчид үнэлгээний тайланг мэргэжилтэнд хүлээлгэн өгнө.
	2021.12.09	Шинжээчдийн үнэлгээний тайланг сургуульд илгээж санал авна.
	2021.12.10	Сургууль үнэлгээний тайлантай танилцаж, тайлбар, нотлох баримтыг мэргэжилтэнд хүлээлгэн өгнө.
	2021.12.13	Шинжээчид үнэлгээний тайланг эцэслэнэ.

Шалгуур шаардлага
/журам/

БМИҮЗ-ийн Удирдах зөвлөлийн 2018 оны 06 дугаар сарын 26-ы өдрийн 08 тоот тогтоолоор баталсан “Боловсролын магадлан итгэмжлэх үндэсний зөвлөлийн Магадлан итгэмжлэх үйл ажиллагааны журам”-ын “Хөтөлбөрийн магадлан итгэмжлэлийн нийтлэг шалгуур шаардлага”

II. Сургалтын хөтөлбөрийн танилцуулга

Монгол Улсад Ой модны салбар үүсэж хөгжсөн 90 гаруй жилийн хугацаанд тус салбарын боловсон хүчнийг бэлтгэх асуудалд онцгой анхаарч иржээ. Анх 1944 онд Улаанбаатар хотод байгуулагдсан “Аж үйлдвэр, барилгын яам”-ны харьяа “Фабрик заводын сургууль”-г мужааны мэргэжлийн ангитайгаар нээж байсан бол Ойн аж ахуй, мод боловсруулах үйлдвэрийн мэргэжлээр анхны дээд боловсролтой 3 инженер 1951 онд тухайн үеийн ЗХУ-ын Новочеркасс хотын Ойн инженерийн дээд сургуулийг төгсжээ. Улмаар 1952 онд Мал аж ахуйн яамны харьяа ХАА-н техникумд Ойн техникчийн анги”-ийг шинээр нээн ойн аж ахуйн мэргэжилтэй үндэсний инженер техникийн ажилтанг эх орондоо бэлтгэх анхны суурь тавигдсан байна. Улмаар 1970-аад онд Сэлэнгэ, Хөвсгөл аймгуудад Ойн техник мэргэжлийн сургуулийг байгуулан мэргэжлийн ойжуулагчдыг бэлтгэж эхэлжээ. Өнөөгийн байдлаар Мэргэжлийн сургалт, үйлдвэрлэлийн төвүүдэд ойжуулагч, цэцэрлэгжүүлэгч зэрэг мэргэжлээр сургалт явуулан мэргэжилтэй ажилчдыг бэлтгэсээр байна. Монгол Улсад ойн салбарын мэргэжилтэй боловсон хүчнийг бэлтгэхэд Ленинградын С.М.Кировын нэрэмжит “Ойн техникийн академи” үнэтэй хувь нэмрийг оруулсан бөгөөд 1960 оноос эхлэн манай улсаас Ойн инженерийн мэргэжлээр элсэн суралцагчдыг хүлээн авч төгсгөсөн байна. 1964 онд ХААДС-д “Ойн аж ахуйн инженер (ОААИ)-ийн анги”-ийг нээн элсэлт авснаар 1967 онд анхны 19 мэргэжилтэнг эх орондоо бэлтгэжээ. Улмаар 1969 оноос ХААДС нь ОААИ-ийн ангиас гадна Ойн инженер - механик, Ойн инженер - эдийн засаг зэрэг ангийг шинээр нээсний сацуу МУИС-ийн харьяа Политехникийн дээд сургуульд (1971 оноос) Мод боловсруулах үйлдвэрийн механикч, технологич зэрэг хавсарсан мэргэжлээр элсэлт авч эхэлжээ.

Ойн салбар нь 1985-1990 оны үед улс ардын аж ахуйн томоохон салбар болон хөгжсөн бөгөөд дотоодын нийт бүтээгдэхүүний 10 гаруй хувийг үйлдвэрлэж байсан түүхтэй. Тухайн үед ойн салбарт ажиллагчдын тоо 10.0 гаруй мянгад хүрч, боловсон хүчнээр хангах асуудлыг төрийн бодлогын хэмжээнд үе шаттайгаар хэрэгжүүлж иржээ. Харин 1990 оноос эхлэн ойн үйлдвэрлэл эрхэлдэг томоохон аж ахуйн нэгжүүд хувьчлагдаж, олон тооны жижиг аж ахуйн нэгж болон задарсан билээ. Өнөөгийн байдлаар Монгол Улсын хэмжээнд ойн салбарын мэргэжилтэн бэлтгэдэг төрийн өмчийн 3 их сургууль, хувийн ба гадаадын хөрөнгө оруулалттай нэг сургууль үйл ажиллагаа явуулан бакалаврын зэрэгтэй мэргэжилтэн бэлтгэн гаргаж байна.

МУИС-ийн бүтцийн өөрчлөлтийн дагуу 2014 оны 2-р сард тус тэнхим нь Хүрээлэн буй орчин судлал, химийн инженерчлэлийн тэнхим нэртэйгээр үүсгэн байгуулагдсан. Улмаар 2016 оны 6-р сард ахин бүтцийн өөрчлөлт хийгдэн Хүрээлэн буй орчин, ойн инженерчлэлийн тэнхим нэртэйгээр үйл ажиллагаагаа явуулж байна. Тус тэнхим нь

Бакалаврын түвшний 4, магистрын түвшний 3, докторын түвшний 2 сургалтын хөтөлбөрийг хэрэгжүүлж байна.

III. Шинжээчийн үнэлгээ, дүгнэлт

Шалгуур 1. Хөтөлбөрийн төлөвлөлт

Оролцогч болон сонирхогч талуудын хэрэгцээг хангахад чиглэсэн, үйл ажиллагааны төлөвлөлт, зохицуулалтын цогц баримт бичгийг нийтлэг шаардлагын дагуу иж бүрэн боловсруулан баталгаажуулж, тогтмол сайжруулдаг байна.

1.1. Хөтөлбөрийн хэрэгцээ, шаардлага

Хөтөлбөр нь үндэсний болон олон улсын боловсролын чиг хандлагыг баримжаалан, сургалтад оролцогч, сонирхогч талуудын хэрэгцээг хангахад чиглэн боловсруулагдсан байна.

Илрэл нотолгоо:

- БСШУС-ын сайдын 2014 оны 05 дугаар сарын 22-ны өдрийн А/52 тоот тушаалаар хөтөлбөрийн нэр, индексийг баталсан. /Ойн аж ахуй, D082101/ 2015-2020 оны хооронд “Ойн аж ахуй” хөтөлбөрийн эрэлт хэрэгцээг тодорхойлж, оролцогч талаас ирсэн саналууд, Монгол оронд ойн салбарын дээд боловсрол олгох үйл ажиллагаа эрхэлдэг төрийн 6 их сургуулийн хооронд хамтран ажиллахаар байгуулсан хамтын ажиллагааны санамж бичиг (2016-03-21), хэлэлцүүлэг, ярилцлагуудын тэмдэглэл, ойн хөгжлийн бодлоготой холбоотой эрх зүйн баримт бичгүүд, дотоодын 2, гадаадын 3-н их сургуулийн хөтөлбөрт хийсэн дүн шинжилгээ, санал зөвлөмж, төгсөгч мэргэжилтний хэрэгцээ шаардлагад тулгуурлан хөтөлбөрийг байнга сайжруулдаг байна. STEEP дүн шинжилгээний аргаар төгсөгчдийн ур чадварыг загварчлах, тодорхойлох үйл ажиллагаанд сайжруулалт хийхээр төлөвлөн ажиллаж байна.

Шалгуурыг хангасан байдал: Бүрэн хангасан.

Онцлог зүйл/Туршлага:

- Оюутанд ойн экосистем, түүний тогтвортой менежмент, ой хамгаалал, ойн нөхөн сэргээлттэй холбоотой асуудлыг шийдэх шинжлэх ухааны үндэслэлийг боловсруулах мэдлэг, ур чадварыг эзэмшүүлэх, мэргэшүүлэх зорилготой сургалтын хөтөлбөрийг хэрэгжүүлж байна.
- “Ойн аж ахуй” хөтөлбөрийг олон улсын ижил төстэй сургалт явуулдаг томоохон их сургуулиудын хөтөлбөртэй дүйцүүлэн, мэргэжлийн зах зээлийн хэрэгцээг хангах зарчмаар боловсруулсан.

Анхаарах асуудал:

- Нийгэм, эдийн засаг, технологи, салбарын хөгжлийн ирээдүйн төлөв, сонирхогч талуудын эрэлт хэрэгцээнд нийцүүлэн дүн шинжилгээ хийх, хөтөлбөрийн үйл ажиллагааны төлөвлөгөө загвар боловсруулах.

Зөвлөмж:

- “Ойн аж ахуй сургалтын хөтөлбөрийн хүрээнд төрийн ба төрийн бус байгууллагууд, аж ахуй нэгжүүдэд 7, 10 хоногоор сургалт, үйлдвэрлэлийн дадлагыг хийлгэж, суралцагчдын чадамжийг нэмэгдүүлэх.

1.2 Хөтөлбөрийн зорилго

Хөтөлбөрийн зорилго нь үндэсний мэргэшлийн хүрээ, байгууллагын эрхэм зорилго, зорилт, холбогдох мэргэжлийн салбар болон оролцогч талуудын хэрэгцээ, шаардлагад нийцсэн байна.

Илрэл нотолгоо:

- МУИС нь шинжлэх ухааны үндсэн салбаруудыг хамарсан чөлөөт мэдлэг буюу "либерал арт" уламжлалд суурилсан хөтөлбөртэй, байгалийн ухаан, эдийн засаг, нийгмийн хөгжлийн суурь асуудлаар сургалт, судалгааны ажлыг тогтвортой эрхэлж, эрдэм мэдлэгийг түгээн дэлгэрүүлэх эрхэм зорилгыг баримтлан ажиллаж байна.
- Хөтөлбөрийн багийн бэлтгэсэн баримт бичгүүд, хөтөлбөрийн баримт бичиг.

Шалгуурыг хангасан байдал: Бүрэн хангасан.

Онцлог зүйл/Туршлага:

- “Ойн аж ахуй” бакалавр зэрэгтэй мэргэжилтэнд тавигдах шаардлага, мэргэжлийн тодорхойлолтыг томъёолохдоо өнөөгийн нийгмийн, ажил олгогчийн эрэлт хэрэгцээнд бүрэн нийцүүлэхийг зорьж, төгсөгчдийн ур чадвар, хандлага нь дээрх шаардлагыг хангасан байна.
- Төгсөгчдийн эзэмших мэдлэг, ур чадвар, хандлагыг МУИС болон Хэрэглээний шинжлэх ухаан инженерчлэлийн сургуулийг хөгжүүлэх мастер төлөвлөгөө, “МУИС-ийн эрхэм зорилго, зорилтуудтай уялдуулан томъёолж өгсөн.
- “Ойн аж ахуй” мэргэжлийн хөтөлбөрийн зорилго, зорилтуудыг тодорхойлох, түүнд хамт олон, тодорхой тооны оюутнууд, ажил олгогчдын төлөөлөл, сонирхогч, хандивлагч, төгсөгчдийн төлөөллийг татан оролцуулдаг.

Анхаарах асуудал:

- Ойн салбарын өнөөгийн хандлага, тогтвортой менежмент, эрэлт хэрэгцээг хангахад төгсөгчдийн загварыг сайжруулах.

Зөвлөмж:

- Зах зээлийн эрэлт хэрэгцээнд нийцүүлэн төгсөгчид, ажил олгогчдоос давтамжтай судалгаа авч, хөтөлбөрийн агуулгын үе шаттайгаар шинэчлэх сайжруулах.
- Хөтөлбөр нь оюутны бие даан суралцах, асуудал дэвшүүлэх, асуудалд дүн шинжилгээ хийх (*critical thinking*), орчин үеийн мэдээллийн технологийг ашиглан мэдлэг эзэмших, бүтээлчээр тасралтгүй бие даан суралцах үйл явцыг дэмжихэд туслах.

1.3. Хөтөлбөрийн төлөвлөлтийн баримт бичгүүд

Сургалтын төлөвлөгөө, хичээлийн хөтөлбөр нь тухайн хөтөлбөрөөр суралцагчид олгох мэдлэг, ур чадвар, хандлагын агуулга, сургалтын үр дүнд чиглэсэн арга зүй, сургалтын үнэлгээний оновчтой хэлбэрийг бүрэн багтааж, оролцогч болон сонирхогч талуудын санал зөвлөмжийг тусган тогтмол сайжруулдаг байна.

Илрэл нотолгоо:

- Батлагдсан сургалтын төлөвлөгөө нь “Ойн аж ахуй” мэргэжлийн шаардлага хангасан гэж үзэн МУИС-ийн захирлын 2015 оны 05 дугаар сарын 22 -ны өдрийн А/259 тоот тушаалаар баталсан. Хичээлийн хөтөлбөрүүдийг боловсруулж, хэрэгжүүлж байна.
- Дээд боловсролын үндэс буюу ойлгомжтой ярих, бичих; тоон болон тоон бус мэдээллийг боловсруулах; олон ургалч үзэл баримтлалын учир шалтгааныг таньж мэдэх, бусад мэргэжлийн хүмүүстэй үр дүнтэй хамтарч ажиллах, харилцан суралцах, мэдлэг ур чадварыг эзэмшүүлэх зорилготой заавал болон сонгон суралцах хичээлүүд байна.
- Хөтөлбөрийн суурь мэдлэг, мэргэжлийн чиглэлийн анхдагч ур чадварыг эзэмшүүлэх, мэргэжлийн ёс зүй, эрх зүйн суурь ойлголтыг өгөх зорилготой заавал болон сонгон судлах хичээлүүд байна.
- Оюутны суралцах үндсэн мэргэжлийн тодорхой мэдлэг, чадвар, дадлыг олгох, заавал болон сонгон суралцах хичээлүүд байна.
- Оюутны хавсарга болон хос мэргэжил эзэмших, магистрын хөтөлбөрийн зарим хичээлүүдийг судлах, их сургуулийн хэмжээнд хүссэн хичээлээ сонгон үзэхэд зориулагдсан хичээлүүд байна. Тухайн хичээл нь залгамж холбоотой бол өмнөх хичээлийг заавал үзсэн байна.

Шалгуурыг хангасан байдал: Бүрэн хангасан.

Онцлог зүйл/Туршлага:

- Ойн аж ахуй мэргэжлээр төгсөгч, мэргэжилтэнд тавигдах шаардлага, мэргэжлийн ур чадварыг 3 чиглэлээр (салбарын шинжлэх ухааны мэдлэг, хувь хүний мэргэжлийн болон хөрвөх ур чадвар, хандлага харилцааны ур чадвар) тодорхойлсон.

Анхаарах асуудал:

- Дээд боловсролын шинэчлэлтэй холбоотойгоор “Ойн аж ахуй” бакалаврын сургалтын хөтөлбөрийн хичээл мэргэшүүлэх, мэргэжлийн хичээлийн залгамж холбооны дараалал нийцэж буйд хяналт тавих.

Зөвлөмж:

- Ойн аж ахуй салбарын хөдөлмөрийн зах зээлд эзлэх байр суурийг тодорхойлох, боломжийг судлан ажил олгогч, төгсөгчид, суралцагчдын саналыг төлөвлөгөөнд тусгаж, ажиллах нь зүйтэй.

1-р шалгуурын талаарх шинжээчийн эцсийн үнэлгээ: БҮРЭН ХАНГАСАН.

Шалгуур 2. Сургалтын үйл ажиллагаа

Сургалтын үйл ажиллагаа нь сургуулийн эрхэм зорилгод нийцэж, хөтөлбөрийн үр дүнд чиглэсэн, цогц чадамжид суурилсан, агуулга, арга зүй нь тасралтгүй хөгжин сайжирдаг байна.

2.1 Хөтөлбөрийн сургалтын агуулга, түүний шинэчлэл

Сургалтын агуулга нь суралцагчийн эзэмших цогц чадамжийг олгоход чиглэсэн, онол практикийн зохистой харьцаатай, давхардалгүй, харилцан уялдаатай, сонгох боломжтой, тасралтгүй хөгждөг байна.

Илрэл нотолгоо:

“Ойн аж ахуй” хөтөлбөрөөр суралцан төгсөгчдөд дараах үндсэн суралцахуйн үр дүнг хүргэхээр төлөвлөсөн байна. Үүнд:

- Суралцахуйн үр дүн-1: Хүрээлэн буй орчинд олон талт үйлчилгээ үзүүлэх ойн экосистемийн тогтвортой байдлыг хангах, суурь мэдээллийг цуглуулах, боловсруулалт хийх, түүнд хэрэгжүүлэх үйл ойн аж ахуйн арга хэмжээг төлөвлөхөд шаардагдах суурь мэдлэгтэй болгох
- Суралцахуйн үр дүн-2: Төгсөгчид багаар, үр дүнтэй хамтран ажиллах чадвартай, ажлын байрны шаардлагыг хангасан, ойн аж ахуйн үйл ажиллагааг удирдан зохион байгуулах мэдлэг чадвар эзэмшүүлэх
- Суралцахуйн үр дүн-3: Эзэмшсэн мэргэжлийн дагуу байгаль хамгаалал, хот суурин газрын ногоон байгууламжийн төлөвлөлт, судалгаа шинжилгээний байгууллагад үр дүнтэй ажиллах мэргэжилтэн бэлтгэх
- Суралцахуйн үр дүн-4: Нийгмийн эрэлтийг хангахуйц ойн тогтвортой менежментийг хэрэгжүүлэх, ойг хамгаалах, зүй зохистой ашиглах, нөхөн сэргээх, ойжуулах мэргэжлийн ур чадвар бүхий мэргэжилтэн бэлтгэх
- Суралцахуйн үр дүн – 5: Ойн аж ахуй, боловсрол, судалгаа шинжилгээний байгууллагад ажиллах, манлайлах, мэргэжлийн түвшин, ур чадвараа байнга дээшлүүлэх эрмэлзлэл бүхий төгсөгчийг бэлтгэдэг гэж тэмдэглэсэн байна.
- Судалгаанд оролцсон нийт төгсөгчдийн үнэлгээг бүхэлд нь авч үзвэл нийт судалгаанд хамрагдагсадын 35-45% нь тус хөтөлбөрийг “маш сайн” болон “сайн” хэмээн үнэлсэн байна. Харин “дунд зэрэг” болон “муу” гэсэн үнэлгээг 15-3% өгсөн бол, “маш муу” гэсэн үнэлгээг судалгаанд хамрагдагсадын 1% өгсөн ба, 2% бөглөөгүй хоосон орхисон байна.
- “Ойн аж ахуй” хөтөлбөрөөр олгогдсон онолын мэдлэг, сонгон судласан хичээлийн ач холбогдолыг санал асуулгад хамрагдагсадын 54-53% нь “сайн”, 19-23% нь “дунд”, 1- 2% нь “дунд” болон “муу” хэмээн үнэлсэн байна.
- Хөтөлбөрийн сургалтын агуулгыг үнэлэх зорилгоор онолын болон практик мэдлэг, мэргэжлийн заавал болон сонгон судлах, дадлагын хичээлүүдийн ач холбогдолыг нийт суралцагчдын 30% нь “маш сайн”, 50% нь “сайн”, 16% нь “дунд зэрэг”, харин 2% нь “муу”, 1% нь “маш муу” хэмээн үнэлсэн байна. Эдгээр асуулгуудыг оролцогчдын 2% бөглөөгүй хоосон орхисон байна.

Шалгуурыг хангасан байдал: Бүрэн хангасан.

Онцлог зүйл/Туршлага

- “Ойн аж ахуй” хөтөлбөрийн төгсөгч нар эзэмшсэн мэргэжлээрээ шинжлэх ухаан, боловсрол, төрийн болон бизнесийн олон салбарт хөрвөн ажиллах өргөн боломжтойг илтгэж байна. Энэ хөтөлбөрт тусгагдсан хичээлүүдийг үзэж судалснаар төгсөгчид мэргэжлийн болон хувь хүний чадамжуудыг бүрэн хэмжээнд эзэмших боломжтой байгаа тул сургалтын агуулга нь хөтөлбөрийн хүрэх үр дүнтэй бүрэн нийцэж байна.

Анхаарах асуудал:

- Үр дүнд суурилсан боловсролын сургалтын арга зүй CDIO-г нэвтрүүлэх сургалтын агуулгыг баталгаажуулах.

Зөвлөмж:

Урт, богино хугацааны стратеги төлөвлөгөөг боловсруулахдаа *innovation teaching in higher education* цуврал сургалт, үр дүнд суурилсан боловсролын сургалтын арга зүй болох CDIO-ийг нэвтрүүлэх сургалтыг зохион байгуулах, мэргэжлийн хичээл заадаг багш нарыг хамруулах.

2.2 Сургалтын арга зүй

Сургалтын арга зүй нь хөтөлбөрийн зорилгод нийцсэн, цогц чадамжид суурилсан, суралцагч төвтэй, мэдээлэл, харилцаа холбооны дэвшилтэт технологи ашигладаг байна.

Илрэл нотолгоо:

- Сургалтын арга нь чадамжид суурилсан, ажил олгогч, салбарын байгууллагуудад хүлээн зөвшөөрөгдсөн, техникийн дэвшил, технологийг даган хөгжих боломжтой байхын дээр суралцагч өөрийн сурах хэрэгцээнд тулгуурлан сонгож судлах нөхцөлийг бүрдүүлсэн байна.
- Багш нарын заах арга зүйн чадварт үнэлгээ хийх зорилгоор 2014-2020 онуудад 6 хичээлийн жилийн хугацаанд суралцагчдаас сэтгэл ханамжийн судалгаа авч үнэлсэн байна.
- Сэтгэл ханамжийн судалгааны судалгааны үр дүнгээс үзвэл, багшийн заах арга зүй, цахим сургалтын арга болон технологи ашиглан сургах хэлбэр, оюутны бие даах чадвар, төлөвшилд чиглэсэн багшийн үйл ажиллагаатай холбоотой үнэлгээ дунджаар 2.41 (80.4%) байна.
- “Ойн аж ахуйн хөтөлбөрт суралцагч суралцах хугацаандаа нийт 120 багц цаг судалсан байхаар төлөвлөгдөн (шалгуур 1.3-д буй хөтөлбөрийн баримт бичиг хэсгээс дэлгэрэнгүй үзнэ үү) батлагдсан. Тус 120 багц цагийн 25% буюу 30 багц цагийг МУИС-ийн шаардлагад тавигдсан ерөнхий суурь хичээлүүд, 17.5% буюу 21 багц цагийг мэргэжлийн суурь хичээлүүд, 45% нь буюу 54 багц цагийг мэргэжлийн заавал судлах хичээл, 12.5% нь буюу 15 багц цагийг мэргэшүүлэх чөлөөт сонголтийн хичээлүүдээс сонгон судлах шаардлагатай. Суралцагч нэг улиралд

сонгон судлах хичээлийн багц цаг болон цагийн ачаалал нь МУИС-ийн сургалтын журмаар зохицуулагддаг.

Шалгуурыг хангасан байдал: Бүрэн хангасан.

Онцлог зүйл/Туршлага:

- Сургалтын удирдлагын систем арга зүйг цаашид сайжруулах суурь дэд бүтэц болох Си Си систем хөгжсөн.

Зөвлөмж:

- “Ойн аж ахуй” хөтөлбөрийг цаашид сайжруулахад ажил олгогчдын санал болгосон ерөнхий дадал, ур чадваруудыг эзэмшүүлэх, дадлагажуулах, хичээлүүдийг сургалтын хөтөлбөрт оруулах. Тухайлбал: Хөрс судлал, Уур амьсгалын өөрчлөлтөд дасан зохицохуй, Ойн мелораци, Бордох технологи.

2.3 Суралцагчийн үнэлгээ

Суралцагчийн эзэмшсэн мэдлэг, чадвар, хандлагыг бүрэн үнэлдэг арга зүйтэй, тасралтгүй сайжруулдаг байна.

Илрэл нотолгоо:

- МУИС нь тухайн хөтөлбөрт суралцагчийн эзэмшсэн мэдлэг, чадварыг үнэлэхдээ тэдний бие даан суралцах үйл ажиллагааг хөхиүлэн дэмжих, хөгжүүлэх, оюутны сурах, багшийн сургах хариуцлагыг өндөржүүлэх зарчмыг удирдлага болгодог ба суралцагчийн мэдлэг, чадварын үнэлгээний талаар “МУИС-ийн сургалтын журам”-ын 2.4, 4.6 дахь зүйлд тусгасан байна.
- “МУИС-ийн сургалтын журам”-д заасны дагуу үнэлгээнд шинжлэх ухааны үндэстэй, бодитой, шударга, ил тод байх зарчмыг баримталдаг. Багш нь ирц идэвхийн оноо, явцын үнэлгээ болон шалгалтын дүнг тогтмол сургалтын мэдээллийн системд оруулдаг ба ингэснээр суралцагч өөрийн ирц, явцын оноо үнэлгээтэй танилцах боломжийг бүрдүүлдэг.
- Хичээлийн тодорхойлолтод тухайн хичээлийг судалснаар суралцагчийн эзэмших мэдлэг, чадвар бүрийг хичээлийн сэдэв бүрээр нарийвчлан боловсруулахын зэрэгцээ улирлын явцын болон эцсийн шалгалтын оноог хэрхэн үнэлэх аргачлал, онооны хуваарилалтын талаар дэлгэрэнгүй мэдээллийг хичээлийн улирлын эхэнд оюутанд хүргэдэг.
- “Ойн аж ахуй” хөтөлбөрийн мэргэжлийн заавал судлах хичээлд (16 хичээл) суралцагчдын авсан дүнгийн сүүлийн 5 жилийн статистик үзүүлэлтээр сургалтад хамрагдсан нийт суралцагсадын 34% -“А”, 37% - “В”, 11%- “С”, 7% - “D”, 8% - “F” үнэлгээгээр үнэлэгдсэн ба үлдсэн 3% нь тухайн хичээлийн улиралд үнэлэгдэлгүйгээр дахин судлах хүсэлт гарган “W” үнэлгээг авсан.
- Хөтөлбөрийн мэргэжлийн сонгон судлах хичээлийн (10 хичээл) сүүлийн 5 жилийн үнэлгээний статистик үзүүлэлтээр нийт суралцагсадын 14% -“А”, 35% - “В”, 25% - “С”, 16% - “D”, 8% “F” үнэлгээгээр тус тус үнэлэгджээ. Дээрх тоон үзүүлэлтүүдийг нэгтгэн дүгнэвэл, нийт суралцагсадын 70% нь мэргэжлийн заавал судлах

хичээлүүдэд, 49% нь сонгон судлах хичээлүүдэд хангалттай сайн (А болон В) үнэлэгдсэн байна.

Шалгуурыг хангасан байдал: Бүрэн хангасан.

Онцлог зүйл/Туршлага:

- Суралцагчдын сурлагын амжилт сүүлийн таван жилд тогтмол өсөж байна.

Анхаарах асуудал:

- Хувь хүний хандлага, ур чадварыг үнэлэх үнэлгээний үзүүлэлтийг тодорхой болгох.

Зөвлөмж:

- Суралцагчийг үнэн бодитой дүгнэх, оновчтой арга нэвтрүүлж, тэднийг идэвхжүүлэх, тасралтгүй хөгжих боломж олгох.

2-р шалгуурын талаарх шинжээчийн эцсийн үнэлгээ: БҮРЭН ХАНГАСАН.

Шалгуур 3. Хөтөлбөр хэрэгжүүлэх орчин, нөөц

Хөтөлбөрийн зорилго, зорилтыг үр дүнтэй хэрэгжүүлэх, амжилттай суралцахад дэмжлэг үзүүлэхүйц шаардлагатай нөөцийг бүрдүүлсэн байна.

3.1 Сургалтын орчин

Сургалт, судалгаа явуулах анги танхим, лаборатори, урлан, багаж хэрэгсэл, багшийн ажиллах орчин нь хөтөлбөрийг үр дүнтэй хэрэгжүүлэх шаардлага хангасан, стандартад нийцсэн шинэчлэл хийдэг байна.

Илрэл нотолгоо:

- “Монгол Улсад шаардлагатай тэргүүлэх чиглэлийн мэргэжлийн нэг болох МУИС-ийн дэргэдэх ХШУИС-ийн Хүрээлэн буй орчин, ойн инженерчлэлийн тэнхимийн “Ойн аж ахуй” (D082101) хөтөлбөрийн чиглэлээр суралцаж буй оюутнуудад олж авсан онолын мэдлэг, эзэмших мэргэжлийн үйлдвэрийн дадлагын ажлыг явуулахад стандарт шаардлага хангасан сургалтын эрүүл, аюулгүй, таатай орчинг (мэргэжлийн 5 анги танхим, багшийн ажлын 3 өрөө, компьютерын 1 лаборатори, уншлагын танхим, бие даан суралцах 1 төв, сургалт судалгааны 3 лаборатори, сургалт судалгааны 2 бааз төв) бүрдүүлсэн нь уг хөтөлбөр үр дүнтэй, бодитой хэрэгжих боломж хэдийн бий болсон байна.
- Оюутныг дадлагажуулах, мэргэжлийн ур чадварыг нь хөгжүүлэх орон зайг бүрдүүлэх үүднээс мод үржүүлгийн технологи туршилт дадлагын бааз суурь бүхий Төв аймгийн Батсүмбэр дэх 2000 га “Ойн сургалт, судалгааны төв”-д олон тооны, өндөр нарийвчлал бүхий хэмжилтийн багаж төхөөрөмж болон иж бүрэн усалгааны системтэй 5 ш хүлэмж, цахилгаан хангамж болон 2 ширхэг гүний худаг, 4 га талбайд чацарганы плантаци бүхий хамгаалалтын хашаа зэрэг тохилог орчинг бүрдүүлжээ.

Онцлог зүйл/Туршлага:

Уг хөтөлбөрийн хүрээнд онолын болон үйлдвэрийн практик мэдлэгээ лаборатори болон хээрийн дадлагаар олж авах эрэлт хэрэгцээ, бие даах, багаар суралцах нөхцөл бүхий хичээлийн агуулга, дараалалтай уялдуулан шаардлагад нийцсэн олон улсын хэмжээнд ойртуулсан лаборатори орчинг бүрдүүлсэн байна.

- Дендрохнологийн лаборатори
- Ойн экосистемийн мониторингийн лаборатори
- Ойн генетик, экофизиологийн лаборатори

Мөн мэдлэг инновац шингэсэн бодит практик үр дүн илрэлүүд бүхий судалгаа, үйлдвэрлэлийн төвүүдээ түшиглэн мэргэжлийн арга барил эзэмших дадлагын ажлын төрөл, чиглэлийг нэмэгдүүлэхэд анхаарч сургалт судалгааны дадлагын хичээлийг холбогдох журам, удирдамжийн дагуу явуулах орчинтой байна.

- Төв Азийн бүсийн түймрийн менежментийн төв
- Төв аймгийн Батсүмбэр дэх “Ойн сургалт, судалгааны төв”
- БШУЯ-ны баталсан нэг оюутанд ноогдох талбайн стандарт 1.47 м2 байгаа бол Ойн аж ахуй хөтөлбөрт суралцагч 1 оюутанд 2.35 м 2 талбай ноогдож байгаа нь давуу тал байна.

Шалгуурыг хангасан байдал: Бүрэн хангасан.

3.2. Сургалтын хэрэглэгдэхүүн

Хөтөлбөрийн онцлогоос хамааран зайлшгүй шаардлагатай сургалт, судалгааны программ хангамж, хичээлийн хэрэгсэл, материаллаг нөөцөөр хангадаг байна.

Илрэл нотолгоо:

- Тус хөтөлбөрөөр зайлшгүй уншиж судалбал зохих номын жагсаалт, үндсэн ба туслах чанарын сурах бичиг зэрэг холбогдох ном, сурах бичиг, гарын авлага, тараах материал зэрэг нийт сурах бичгийн 44.8% нь монгол хэлээр хэвлэгдсэн, 31.2% нь орос хэлээр, 22% нь англи хэлээр хэвлэгдсэн сурах бичиг эзэлж байгаа нь тус хөтөлбөрийн суралцагчдад уншиж, судлах гадаад, дотоодын үндсэн сурах бичиг хангалттай бүрдүүлсэн байна.
- Хөтөлбөрийн онцлогоос хамааран зайлшгүй шаардлагатай сургалт, судалгааны Си Си мэдээллийн систем, хичээлийн хэрэгсэл, практикийн материаллаг нөөц, нэг бүрийн хэрэгсэл, хэвлэмэл үзүүлэн, дижитал, видео, аудио эх үүсвэр, сургалт судалгааны лицензгүй нээлттэй эх үүсвэрийн болон төлбөртэй программуудыг ашиглах зэргээр олон эх үүсвэр бүрдүүлжээ.
- Мөн зохих сургалтад ашиглаж буй хэмжилтийн багаж, төхөөрөмжтэй ажиллах заавар, хэмжилт хийх аргачлал зэрэг удирдамж арга зүйгээр тусгайлан хангадаг байна.
- Статистик боловсруулалтын (Sigma Plot 14.0, SysStat Inc., SAS, SAS Institute Inc.) болон зургийн анализийн програм (Image J, WinRhizo, WinFolia, WinSeed, Regent Instrument Inc., ToupView, ToupTek Photonics Co Ltd., Amscope, Amscope Co Ltd.) модны өсөлт, уур амьсгалын өөрчлөлтийн судалгаанд CDendro - Cybis dendro dating

program, Program ARSTAN, CDendro - Cybis dendro dating program, COFECHA зэрэг дендрохронологийн судалгааны программ хангамжтай.

- Мөн цаашид энэхүү хөтөлбөрийн чиглэлээр үйл ажиллагаа явуулж байгаа зарим мэргэжлийн байгууллага, компанид оюутан залуусыг практик дадлагад гаргах, сургах захиалга бүрдсэн байна.

Онцлог зүйл/Туршлага:

Хөтөлбөрийн онцлогоос хамааран зайлшгүй шаардлагатай сургалт, судалгааны жишиг нөөц санг төрөлжүүлэн бүрдүүлсэн онцлог байна. Үүнд:

- МУИС-ийн гребарийн санд (UBU) ой ургамжлын индикатор ургамлын үр жимс, үр бүхий 64 овгийн 230 зүйлийн модлог, өвслөг болон доод ургамлын зэрэг 500 гаруй жиших цуглуулга сургалтын материалтай.
- Модлог ургамлын 90 гаруй зүйлийн хатаадас, 5000 гаруй модны өрөмдсөн дээж материалын харьцуулах төрөлжсөн цуглуулгатай
- Монгол орны уур амьсгалын бүс бүслүүрийг төлөөлсөн ойн сангийн хөрсний 3500 орчим дээж материалын цуглуулгатай.
- 70 гаруй ургамлын анатоми бүтцийг харуулсан слайд, үрийн дээж, ойн хөнөөлт шавжийн үзүүлэн таниулах материал бүрдүүлэн ашиглаж байна.
- Ойн тооллогын 400 цэгийн тоон мэдээг бүрдүүлсэн зэрэг онцлог давуу талууд байгаа нь хэмжилт судалгааны анхдагч материалуудыг сургалтад ашиглах боломжийг бүрдүүлжээ.
- Багш нар Европын холбооны Erasmus-ын санхүүжилттэй их сургуулиудын зарим хичээлүүдийн e-content/online хичээлийг онлайн платформд байршуулах ажлыг 2020 оноос эхлэн амжилттай эхлүүлжээ.

Анхаарах асуудал:

“Ойн аж ахуй (D 082101)” хөтөлбөрийн чиглэлээр суралцагчдад анхан шатны мэдлэг олгох ном сурах бичгийн хүрэлцээг хангуулах.

Шалгуурыг хангасан байдал: Бүрэн хангасан.

3.3. Номын сан, мэдээллийн эх үүсвэр

Багш, суралцагчдын сургалтын үйл ажиллагааг амжилттай хэрэгжүүлэхэд дэмжлэг үзүүлэхүйц хэрэгцээт ном сурах бичиг, мэдээллийн эх үүсвэрээр тогтмол, чанартай хангадаг байна.

Илрэл нотолгоо:

- “Ойн аж ахуй” хөтөлбөрт суралцагчид бие даан суралцах, мэдлэгийг баталгаажуулах, мэргэжлийн болон мэргэшүүлэх хичээлийн сургалтын материал, мэдээллийг хэвлэмэл болон онлайн эх сурвалжийг ашиглан эзэмших боломж бүрдүүлэн ажиллаж иржээ. Үүнд:
- МУИС-ийн номын сангийн нэг цэгийн үйлчилгээ нь шаардлагатай ном, сурах бичгийг захиалах, хүлээн авах, бий болгох зэрэг бусад лавлагаа тусламжийг өгөх үйлчилгээг бүрдүүлжээ.
- Тус номын сангийн орчин утастай болон утасгүй интернетийн сүлжээгээр бүрэн хангагдсан байсан бөгөөд Монгол (126.3 м²) болон гадаад (250.5 м²) 65 хэлээр

хэвлэгдсэн эрдэм шинжилгээний номын фонд, Байгалийн ухааны номын фонд, Уншлагын танхим (516.5 м²), Цахим уншлагын танхим (124.8 м²), Семинарын (4 өрөө) болон бүлгээр ажиллах өрөөнүүд (54.2 м² талбай бүхий 2 өрөө), Мэдээллийн технологийн хэсгүүдтэй байна.

Онцлог зүйл/Туршлага:

- МУИС-ийн Стратеги төлөвлөгөөний “Технологийн дэвшилд суурилсан сургалтын шинэ аргыг хэрэглэх, боловсролын онлайн болон нээлттэй эхүүдийн хүртээмжийг нэмэгдүүлэх, сургалтад ашиглах” зорилтын хүрээнд
- МУИС-д олон улсын номын сангийн автоматжуулсан КОНА цогц программ хангамж өгөгдлийн бааз ашиглах, дэлхийн нэр хүндтэй их сургуулиудын онлайн сэтгүүл, еномын сан ашиглах боломж бүрдүүлсэн зэрэг дэвшилтэт технологиуд нэвтэрч эхэлсэн байна.
- МУИС-ийн “Багшийн хөгжил, цахим сургалтын төв”-ийг түшиглэн онлайн сургалтын контент боловсруулах “Дижитал профессор студи”-ийг байгуулснаар хичээлийг е-контент түвшинд бэлтгэх, СиСи систем болон бусад платформуудыг ашиглан цахим контентыг бэлтгэх зааварчилгаа, сургалтын материалаар багш нарыг хангаж онлайн болон холимог хэлбэрээр суралцагчдад хүргэх боломж бүрджээ.

Анхаарах асуудал:

- “Ойн аж ахуй” хөтөлбөрийн мэргэжлийн суурь болон мэргэшүүлэх сургалтад хэрэглэгдэх сурах бичгийн нэр төрлийг олшруулах, гарын авлагыг зохиох, орчуулан хэвлүүлэх

Зөвлөмж:

Мэргэшүүлэх, мэргэжлийн хичээл заадаг багш нар ном, сурах бичиг гарын авлага туурвих.

Шалгуурыг хангасан байдал: Бүрэн хангасан.

3-р шалгуурын талаарх шинжээчийн эцсийн үнэлгээ: БҮРЭН ХАНГАСАН.

Шалгуур 4. Хөтөлбөрийн удирдлага, зохион байгуулалт

Хөтөлбөрийн удирдлага нь сургуулийн алсын хараа, эрхэм зорилгод нийцүүлэн сургалтын үйл ажиллагааг чанартай, тасралтгүй явуулахад нөөцийг оновчтой хуваарилж; хөдөлмөрлөх, суралцах таатай орчинг бүрдүүлэн хөтөлбөрийн хөгжлийг хангахуйц стратеги, менежментийг хэрэгжүүлнэ.

4.1. Хөтөлбөрийн удирдлагын үйл ажиллагаа

Хөтөлбөрийн удирдлагын үйлчилгээ нь сургалтын чанарыг сайжруулахад чиглэж, нийгмийн хариуцлагатай, оролцогч болон сонирхогч талуудын оролцоог хангадаг байна.

Илрэл нотолгоо:

- МУИС-ийн 2015 оны 12-р сарын 28-ны өдрийн МУИС-ийн Удирдах зөвлөлийн хурлын 13 тоот тогтоолоор МУИС-ийн Стратеги төлөвлөгөөг (2016-2024) баталж, МУИС нь

үндэсний тэргүүлэх их сургуулиас дэлхийн түвшний их сургууль болох хэтийн зорилтыг дэвшүүлсэн байна.

- Хөтөлбөрийн удирдлага зохион байгуулалт нь МУИС-ийн захирлын 2016 оны 12 сарын 23-ны өдрийн А/347 тоот тушаалаар батлагдсан “Хөтөлбөрийн хорооны журам”-ыг мөрддөг.
- Хөтөлбөрийн сургалтын үйл ажиллагааг тухайн жилийн МУИС-ийн ажлын төлөвлөгөө болон стратеги төлөвлөгөөг мөрдлөг болгон сургалтын агуулга, зохион байгуулалтыг сайжруулж иржээ.
- МУИС-ийн захирлын 2016 оны 10 дугаар сарын 21-ны өдрийн А/282 тоот тушаалаар “Ойн аж ахуй” хөтөлбөрийн багш 2 профессор, 1 зөвлөх профессор, 3 дэд профессор, 1 багш, 1 туслах ажилтан, 1 техникч, 1 сахиул гэсэн бүрэлдэхүүнтэй байна.
- ХШУИС-ийн хөтөлбөрийн хороо нь 11, Тэнхмийн хөтөлбөрийн дэд хороо 5 хүний бүрэлдэхүүнтэй тус тус ажиллаж байна.
- МУИС-ийн Захирлын 2014 оны 03-р сарын 07-ны өдрийн А/55 дугаар тушаалаар баталсан “Хөтөлбөрийн хорооны түр журам”, 2014 оны 06-р сарын 04-ний өдрийн А/172 дугаар тушаалаар баталсан “МУИС-ийн Хөтөлбөрийн хорооны 25 түр журмыг хэрэгжүүлэх товч заавар”-ын дагуу боловсруулан сургалтын төлөвлөгөөг батлуулан хэрэгжүүлэхдээ төрийн захиргааны төв байгууллагаас батлан гаргасан “Хөтөлбөрт тавигдах нийтлэг шаардлага”, холбогдох бодлогын баримт бичгийг мөрддөг байна.
- Хөтөлбөрийг боловсруулах, хэрэгжүүлэх, хөтөлбөрийн удирдлага, зохион байгуулалтын гүйцэтгэлийг үнэлэх аргачилал нь хэрэгжиж буй төсөл, оролцогч оюутан судлаач, эрдэм шинжилгээний өгүүлэл, ном сурах бичиг, бүтээлүүд байх ба үүнд, сургалт мэдээллийн ил тод, хяналттай удирдлагын мэдээллийн Си Си системийг нэвтрүүлсэн байна.
- Хөтөлбөрийг хэрэгжүүлэгч нэгжийн удирдлага (тэнхимийн эрхлэгч, хөтөлбөрийн зохицуулагч) нь багш, суралцагчдын идэвх санаачилгыг дэмжих, хөтөлбөртэй холбоотой асуудал, санал, зөвлөмжийг Тэнхимийн хөтөлбөрийн дэд хороогоор дамжуулан сургуулийн захиргаанд илэрхийлдэг.
- МУИС-ийн сургалтын журамд нийцүүлэн тус мэргэжлийн хөтөлбөрөөр төгсөгчдийн компетенц (мэдлэг, чадвар, хандлага), хөтөлбөрийн суралцахуйн үр дүнг тодорхойлж, сургалтын төлөвлөгөө, хичээлийн хөтөлбөрүүдийг боловсруулсан байна.
- Харин хичээлийн эцэст багш бүрийн сургалт, эрдэм шинжилгээ, нийгэмд үзүүлэх үйчилгээний гүйцэтгэлийн тайланг А, Б, В багц цагаар тооцон үнэлэн <https://research.num.edu.mn/>, СиСи систем-д холбогдох мэдээллийг оруулдаг нь хангалттай түвшинд явагддаг гэж үзэж болно.

Онцлог зүйл/Туршлага:

Анхаарах асуудал:

Ойн тухай хууль, дүрэм, журмуудад “Ойн аж ахуй” хөтөлбөрөөр бэлтгэгдэн гарах мэргэжилтний тоо чанарыг сайжруулах заалт тусгуулах.

Шалгуурыг хангасан байдал: Бүрэн хангасан.

4.2. Хамтын ажиллагаа, нийгэмд үзүүлэх үйлчилгээ

Дотоодын болон олон улсын их дээд сургуулиуд, судалгааны болон мэргэжлийн байгууллагууд, төрийн болон ТББ-тай холбоо тогтоож; багш, суралцагч солилцоо, тэтгэлэг ба хамтарсан хөтөлбөр, сургалт, судалгаа, семинар зэрэг хэлбэрээр хамтран ажилладаг байна.

Илрэл нотолгоо:

- Ойн аж ахуй хөтөлбөрийн багш нар “Монгол улсын их сургуульд профессор, багш ажиллуулах журам” (10.1; 13.1 www.num.edu.mn) -ийн багшийн үүргийн дагуу олон нийт, нийгэмд үйлчлэх чиглэлээр сургалт, сурталчилгаа, соёл төлөвшил болон танин мэдэхүйн олон үйл ажиллагаа тогтмол явуулж иржээ.
- Тус хөтөлбөрийн нийт 6 багш, 6 улсын гадаадын их сургууль, лабораториудад ажиллаж, олон улсын чанартай 8 өгүүлэл хэвлүүлж, 12 улсад олон улсын хурал, семинарт оролцож, 36 аман илтгэл, 4 постер илтгэл, 4 судалгааны ажлыг хураангуй байдлаар танилцуулжээ. Тус хөтөлбөрийн багш нар “Монголын Ойн Мэргэжлийн Их Дээд Сургуулийн Консорциум”-ыг 2016 оны 03 сарын 21-нд байгуулснаар МУИС, ХААИС, ШУТИС, ОУУБИС-ийн сургуулиудын хөтөлбөр хооронд оюутан шилжих, багц цаг солилцох, мэргэжлийн хичээлийн хээрийн болон лабораторийн сургалт дадлагыг хамтран явуулах, зарим мэргэжлийн хөтөлбөрийг боловсруулах, заах зэрэгт хамтарч байна. 2016 оноос БОАЖЯ-тай хамтран “Монгол орны Ойн салбарын бодлого, шинжлэх ухаан, технологи” сэдэвт Үндэсний хурлыг жил бүр зохион байгуулж байна.
- Ойн аж ахуй, Ойн аж ахуйн инженер, Ойжуулагч, Цэцэрлэгжүүлэгч хөтөлбөрүүдэд суралцаж буй оюутнуудыг судалгаа шинжилгээний арга зүйд суралцуулах, ажлын үр дүн, бүтээлийг таниулан сурталчилах зорилгоор “Оройн нахиа” Оюутны эрдэм шинжилгээний хурлыг жил бүр уламжлал болгон зохион байгуулж байна.
- 2015 оноос өнөөг хүртэлх хугацаанд МУИС-ийн “Ойн аж ахуй” хөтөлбөрийн оюутнууд ямагт тэргүүн байруудыг эзэлсээр ирсэн нь судалгаа шинжилгээ, сургах, суралцах үйл ажиллагааны чанарыг илтгэхийн зэрэгцээ тус мэргэжлийг сурталчлан таниулах томоохон үйл ажиллагаа болон өргөжсөн байна

Онцлог зүйл/Туршлага:

- Нийгэмд мэдлэгээр манлайлж, нийгмийн хөгжлийн түүчээ байх зорилгын хүрээнд “Ойн аж ахуй” хөтөлбөрийн багш профессорууд нийгэмд хандсан олон төрлийн ажил, сайн дурын ажилд идэвхтэй оролцох, хөтөлбөрийн суралцагч оюутнуудыг өргөнөөр хамруулах, ойн салбарын улс орны хөгжил, салбарын бодлогыг тодорхойлоход оруулах хувь нэмрийг нэмэгдүүлэхэд анхааран ажиллаж ирсэн байна.
- “МУИС-ийн Ойн сургалт, судалгааны төв” нь нийгмийн хариуцлагын хүрээнд Төв аймгийн Батсүмбэр сумын ЗДТГ-тай хамтран ажиллаж, тус сумын нутаг дэвсгэрт ойжуулалт, нөхөн сэргээлтийн ажил хийж гүйцэтгэх, орон нутагт үйл ажиллагаа явуулж буй ойн нөхөрлөлийг чадавхжуулах, сургалт хийх зэргээр орон нутгийн хөгжилд хувь нэмрээ оруулж байна

Шалгуурыг хангасан байдал: Бүрэн хангасан.

4.3 Санхүүжилт

Хөтөлбөрийн санхүүжилтийн тодорхой хувь нь багш, суралцагчийн хөгжилд зарцуулагддаг, олон эх үүсвэртэй байна.

Илрэл нотолгоо:

Байгууллагын бие даасан байдлыг хангаж, менежментийн олон улсын шилдэг арга барилыг нэвтрүүлэн, санхүүгийн тогтвортой байдлыг хангах тэргүүлэх чиглэлийн хүрээнд:

- Ойн аж ахуй хөтөлбөрийн санхүүгийн бие даасан байдал 2016 оноос МУИС-ийн “Багш ажилтныг дэмжих зардал” олгогдож эхэлснээр жилд олгогддог 12 сая төгрөг нь бие даан зарцуулж буй санхүүгийн эх үүсвэр болдог ба үүнээс хөтөлбөрийн нэг багш, ажилтанд ойролцоогоор 860,000 төгрөг ноогдож байна.
- МУИС-ийн судалгааны ажлын санхүүжилтийн журмыг 2016 оноос эхлэн хэрэгжүүлж, 2018 онд шинэчлэн баталсан. Журмын 2.1, 2.2 заалтуудыг үндэслэн профессор багшид 2 сая, дэд профессор болон 5-с дээш жилийн өмнө докторын зэрэг хамгаалсан ахлах багшид судалгааны лабораторийн удирдагч эсэхээс хамааран 1-3 сая төгрөгийн суурь судалгааны зардал олгож байгаагаас 2018 онд ОАА хөтөлбөрийн нийт 6 багш 10 сая төгрөгийн, 2019 онд 6 багш 10 сая төгрөгийн дэмжлэг авч судалгааны ажилд зарцуулжээ.
- Тус журмын 3.1- т заасны дагуу 45 хүртэлх насны, 3-аас цөөнгүй залуу судлаачдын багт 10 сая, зочин судлаачид 60 сая, докторын дараах судалгааны тэтгэлэгт 20 сая, өндөр түвшний судалгаанд 30 сая хүртэл санхүүжилт олгож эхэлсэн байна.
- Ойн аж ахуй хөтөлбөрт суралцаж буй нэг оюутанд ноогдох зардал ойролцоогоор 2018 онд 2,834,448, 2019 онд 3,227,648 болж өссөн байна. ОАА хөтөлбөрийн нэг оюутанд ноогдох зардал сүүлийн 3 жилийн хугацаанд өссөн байна.
- Сургалтын төлбөрт үргэлжлэн суралцагч оюутны нэг багц цагийн төлбөр дунджаар 4,100 ₮. Харин бүх түвшний оюутнуудын хувьд жилийн төлбөр 101,000 төгрөгөөр буурсан ажээ.

Онцлог зүйл/Туршлага:

- Тус хөтөлбөрийн багш нар сургалтын материаллаг бааз суурийг байнга шинэчлэн, сайжруулсаар ирснээр “Ойн генетик, экофизиологийн лаборатори”-д 91,919,754 төгрөгийн, “Ойн экосистемийн мониторингийн лаборатори”-д 88,197,400 төгрөгийн, МУИСийн Ойн сургалт судалгааны төвд 125,857,507 төгрөгийн буюу нийт 305,974,307 төгрөгийн үнэ бүхий багаж төхөөрөмж, тавилга хэрэгслийг худалдан авч сургалт судалгааны орчин нөхцлийг бүрдүүлжээ.
- Хөтөлбөрийн профессор, багш нар сүүлийн 3 жилд 208 сая төгрөгийн санхүүжилттэй олон улсын байгууллагатай хамтарсан төсөл хэрэгжүүлсний үр дүнд худалдан авсан судалгааны багаж төхөөрөмжийн талаарх мэдээллийг мөн www.research.num.edu.mn болон www.project.num.edu.mn сайтуудаас харах боломжтой.

- Ойн аж ахуй хөтөлбөрийн сургалтанд шаардлагатай үндсэн сурах бичиг, гарын авлага, эрдэм шинжилгээний сэтгүүл, өгүүллийг худалдан авах, сурах бичгийн хангамж, мэдээллийг шинэчлэх оюутанд сургалтын төлбөр өгөх, судлаачаар ажиллуулах, ажлыг жил бүр МУИС-ийн санхүүжилт, багш нарын хэрэгжүүлж буй төслийн зарим санхүүжилтээр гүйцэтгэж байна.

Анхаарах асуудал:

- Төсөв, санхүүгийн хувьд салбар сургуулиас шууд хамааралтай байгаа нь хөтөлбөр, цаашлаад тэнхимийн бие даасан байдал болоод урт хугацааны хөгжил, төлөвлөгөөг удаашруулах талтай.

Шалгуурыг хангасан байдал: Бүрэн хангасан.

4.4. Хөтөлбөрийн маркетингийн идэвхжүүлэлт

Хөтөлбөр нь тогтвортой байдлаа хангахуйц идэвхжүүлэлтийн хөтөлбөр, төлөвлөгөөтэй байна.

Илрэл нотолгоо:

- МУИС-ийн мэргэжлийн хөтөлбөрүүдийн талаарх мэдээллийг олон хэлбэрээр сургалтын нэгдсэн албанаас БСШУСЯ, Аймаг орон нутгийн удирдлагууд, ТББ зэргээр дамжуулан хүргэдэг.
- Хөтөлбөр сонголтын өдөрлөгийг бүрэлдэхүүн сургууль, мэргэжлийн тэнхимүүд, холбогдох алба нэгжийн зүгээс зохион байгуулдаг. Энэ үйл ажиллагаанд салбартаа амжилт гаргаж яваа мэргэжилтнүүд “Мэргэжлээ хэрхэн сонгох вэ”, “Хөдөлмөрийн зах зээлийн эрэлт хэрэгцээ”, “Ирээдүйн чиг хандлагыг ойлгох” гэх мэт цуврал уулзалт ярилцлагад оролцож ажилладаг.
- Хөтөлбөр сурталчлах өдөрлөг нь тухайн хичээлийн жилийн намар болон хаврын улиралд явагддаг.
- Ойн аж ахуй хөтөлбөрийг олон нийтэд танилцуулах, сурталчлах, оюутнуудыг идэвхжүүлэх, сурлагын амжилтыг дээшлүүлэх зорилгоор бакалавр, магистрант, докторант оюутны дунд олон улсын болон үндэсний эш-ний хурлыг жил бүр зохион явуулдаг байна.
- Өсвөрийн ойчдын уралдааныг жил бүр зохион байгуулж иржээ.
- Профессор Н.Баатарбилэгийн Финландын Ойн судалгааны хүрээлэнтэй хамтарсан Олон улсын зуны сургалт (2017), Н.Батхүү (2018) зэрэг үйл ажиллагаа нь ойн аж ахуйн хөтөлбөрийг нийтэд сурталчлахад ихээхэн ач холбогдолтой үйл ажиллагаа болсоор байна.
- Ойн аж ахуй хөтөлбөрийн төгсөгчдийн 800 гаруй гишүүнтэй “Монгол Ой Нийгэмлэг”-ийн групп-ээр дамжуулан хурал, сургалт семинарын болон ажлын байрны мэдээлэл тогтмол солилцож байна.
- Хөтөлбөрийн хөгжлийн ирээдүй, сонирхогч талуудын оролцоог хангах системчлэгдсэн загварыг бий болгох үүднээс тус хөтөлбөрийн эрэлт хэрэгцээг талуудын шаардлагад нийцэж буй эсэх судалгааг явуулж, хөтөлбөрийг сайжруулах алхмыг хийж буй нь дэвшилттэй байна.

Онцлог зүйл/Туршлага:

- Төгсөгчдийн Фэйсбүүк групп, “Ойн тухай ярилцъя” олон нийтийн хэлэлцүүлгийн нээлттэй групп, Олон Улсын Ой Судлаач Оюутан Залуусын Холбооны Монгол дахь салбар буюу Монголын Ой Судлаач Оюутан Залуусын Холбоо зэрэгт мэргэжлийн зөвлөмж өгөн өнөөг хүртэл хамтран ажиллаж байна.

Зөвлөмж:

Төгсөгчдийн мэдлэг мэргэжлийн чадавхыг дээшлүүлэх сургалтыг төгсөгчдийн холбоо болон төрийн болон төрийн бус байгуулагуудаар дамжуулан тогтмол явуулах, төгсөгчдийг мөшгин судлах судалгаагаар хөтөлбөрийн сургалтын чанарыг сайжруулахад чиглэсэн ажлыг тогтмолжуулах

Шалгуурыг хангасан байдал: Бүрэн хангасан.

4.5. Хөтөлбөрийн нээлттэй, ил тод байдал

Хөтөлбөр хэрэгжүүлэгч нэгж нь өөрийн үйл ажиллагааны талаар олон нийтэд үнэн зөв, ил тод, дэлгэрэнгүй, сүүлийн үеийн мэдээллийг түгээдэг байна.

Илрэл нотолгоо:

- Хөтөлбөрийг хэрэгжүүлэгч нэгж нь багш, оюутнууд, элсэгч, төгсөгчдөд үйл ажиллагаагаа ил тод түгээдэг.
- МУИС-ийн элсэлт, бүртгэлийн хэлтэс жил бүр элсэлтийн болон суралцагчийн гарын авлагыг эрхлэн гаргадаг бөгөөд үүнд хөтөлбөрүүдийн тухай мэдээллийг шинэчлэн байршуулдаг.
- МУИС-ийн сургалтын удирдлага, мэдээллийн СиСи систем <https://sisi.num.edu.mn> – ээр дэлгэрэнгүй мэдээллийг хүргэж, тогтмол шинэчилж байна.
- МУИС-ийн Мэдээллийн технологийн газрын хөгжүүлсэн СиСи (<https://sisi.num.edu.mn/>) сургалт, удирдлагын мэдээллийн системийг хөтөлбөртэй холбогдох бүх төрлийн үйл ажиллагаандаа ашиглаж байна.
- Сургалт болон санхүүгийн нэгжүүд, сургуулийн захирлуудын хувьд өөр өөр түвшинд системд хандаж, хөтөлбөрийн хэрэгжилттэй холбоотой бүх төрлийн мэдээлэл авах, тайлан гаргах боломж хангагдсан.
- Дээрх мэдээ мэдээллийг түргэн шуурхай хүргэх зорилгоор албан ёсны цахим хуудас болон facebook хуудсыг тогтмол ажиллуулдаг.
- “Монгол Улсад шаардлагатай тэргүүлэх чиглэлийн мэргэжлийн нэг болох МУИС-ийн дэргэдэх ХШУИС-ийн Хүрээлэн буй орчин, ойн инженерчлэлийн тэнхимийн “Ойн аж ахуй” (D082101) хөтөлбөрийн чиглэлээр суралцаж буй оюутнуудад “тэрбум мод” ургуулах хөтөлбөрийн хүрээнд төсгөлтийн дараагаар ажлын байраар хангагдах боломж нэмэгдэж буйтай холбоотойгоор

-Ур чадвар, мэдлэгийг “Ойн аж ахуй” хөтөлбөрт суралцагч хэрхэн эзэмшсэн талаарх судалгааг 2020 оны төгсөгчдөөс болон МУИС-ийн “Ой судлалын хөтөлбөрийн оюутан, төгсөгчид” цахим хуудсаар (Google forms ашиглан) дамжуулан авсан байна.

- Цар тахлаас үүдэлтэй хорио цээрийн дэглэмийн улмаас хөдөө орон нутагт ажиллаж буй тус хөтөлбөрийн төгсөгчидтэй биечлэн уулзах, судалгаа авахад хүндрэл учирч байлаа.

- Дээрх судалгаа болон ажил олгогчдын “Ойн аж ахуй” хөтөлбөрийг цаашид сайжруулах болон шинэчлэх тохиолдолд санал болгосон ерөнхий дадал болон ур чадваруудыг эзэмшүүлэх, дадлагажуулах, хичээлийн хөтөлбөр, сургалтын үйл ажиллагаанд түүнд чиглэгдсэн сургалтын агуулга, цагийг сайтар тусгах нь чухал байна гэж дүгнэжээ.

Анхаарах асуудал:

Ойн аж ахуйн чиглэлээр их дээд сургуульд суралцаж буй оюутныг бодлогоор дэмжих, санхүүгийн дэмжлэг үзүүлэх, элсэхэд олон талын хөнгөлөлт үзүүлэх асуудлыг оролцогч талуудтай хамтарч хэрэгжүүлэх.

Шалгуурыг хангасан байдал: Бүрэн хангасан.

4-р шалгуурын талаарх шинжээчийн эцсийн үнэлгээ: БҮРЭН ХАНГАСАН.

Шалгуур 5. Суралцагчид чиглэсэн үйл ажиллагаа

Тухайн хөтөлбөрөөр суралцагчдын оролцоог ханган бие даан амжилттай суралцахад чиглэсэн дэмжих үйл ажиллагааг хүртээмжтэй, ашиг сонирхолд нь нийцүүлэн үр дүнтэй хэрэгжүүлдэг байна.

5.1. Суралцагч сонгох, элсүүлэх

Хөтөлбөрийн онцлогт тохирсон шалгуураар элсэгчдийг сонгон шалгаруулдаг байна.

Илрэл нотолгоо:

- 2015 оноос эхлэн БСШУСЯ-аас хэрэгжүүлсэн Дээд боловсролын шинэчлэлийн хүрээнд Монгол Улсын Их Сургууль бакалаврын өдрийн хөтөлбөрт элсэгчдийг тодорхой мэргэжлийн хөтөлбөрт бус харин бүрэлдэхүүн сургуульд бүртгүүлэн элсүүлж, Ерөнхий суурийн тодорхой хичээл судалсны дараа мэргэжлээ сонгох боломжоор хангах бодлогыг хэрэгжүүлж эхэлсэн.

- МУИС-ийг 2016-2024 он хүртэл хөгжүүлэх стратеги төлөвлөгөөний “Сургах ба сурах үйл явцыг дэлхийн тэргүүлэх түвшинд хүргэх” тэргүүлэх чиглэлийн дагуу элсэлтийн бодлогын хүрээнд Монгол улсын өнцөг булан бүрээс шилдэг суралцагчийг элсүүлэхийн тулд дараах үе шаттай арга хэмжээг 2016 оноос авч хэрэгжүүлсэн.

- Шинэ суралцагчдад зориулсан мэдээлэл, гарын авлага элсэхийг хүссэн хүн бүхэнд нээлттэй. МУИС-ийн элсэлтийн танилцуулга, видео шторк, мэдээ мэдээллийг албан ёсны цахим хуудас, сошиал орчин, ТВ, радиогоор түгээдэг.

Шалгуурыг хангасан байдал: Бүрэн хангасан.

Онцлог зүйл/Туршлага:

- Сургалтын журмын 4.6.11.8 заалтын дагуу Монгол улсад Кембрижийн сургалтын хөтөлбөрийг хэрэгжүүлж буй “Орчлон” олон улсын дунд сургууль, 117 БСШУЯ-ны харьяа олон улсын хөтөлбөрийн сургалттай “Шинэ эхлэл”, “Шинэ эрин”, “Монгол тэмүүлэл” лаборатори сургуулиудыг төгсөж МУИС-д элссэн оюутнуудын А болон AS түвшинд судалсан хичээлийг МУИС-ийн Ерөнхий суурийн хичээлтэй багц цаг дүйцүүлэн тооцдог.
- ШУС болон ХШУИС-д элсэгчид гүнзгийрүүлсэн сургалтат хөтөлбөр (honours program)-т хамрагдах боломжтой.

Анхаарах асуудал:

- Бакалаврын өдрийн хөтөлбөрт элсэгчдийг тодорхой мэргэжлийн хөтөлбөрт бус харин бүрэлдэхүүн сургуульд бүртгүүлэн элсүүлж, Ерөнхий суурийн тодорхой хичээл судалсны дараа мэргэжлээ сонгох боломжоор хангах бодлогыг хэрэгжүүлж эхэлсэн нь энэ хөтөлбөрт элсэгчдийн тоо буурахад нөлөөлсөн.

Зөвлөмж:

- Бакалаврын өдрийн хөтөлбөрт элсэгчдийг тоог нэмэгдүүлэхэд анхаарал хандуулах.

5.2. Зөвлөн туслах үйлчилгээ

Суралцагчид суралцах, судлах арга зүй, ирээдүйн ажил мэргэжил, хөдөлмөр эрхлэлт, сэтгэл зүй, хууль эрх зүйн чиглэлээр зөвлөх үйлчилгээг тогтмол, чанартай үзүүлдэг байна.

Илрэл нотолгоо:

- МУИС-ийн эрхэм зорилго, “Сургах ба сурах үйл явцыг дэлхийн тэргүүлэх түвшинд хүргэх” стратегийн чиглэлд оюутан чанартай боловсрол эзэмшин хөгжих таатай орчинг бүрдүүлэн ажилладаг.
- МУИС-ийн Оюутан, төгсөгчийн хэлтэс нь оюутнуудад хөдөлмөр эрхлэлтийн талаар лекц, семинар зохион байгуулах, зөвлөгөө өгөх, цагийн ажилд зуучлах, төгсөгчдийг ажлын байранд зуучлах, өдөрлөг хийх зэрэг үйл ажиллагаануудыг тогтмол удирдан зохион байгуулдаг.
- Жилд 2 удаа хөтөлбөр сурталчлах өдөрлөг зохион байгуулж, 1-р түвшний оюутнуудад МУИС-ийн хөтөлбөрүүдийг танилцуулж, мэргэжлийн хөтөлбөрөө хэрхэн сонгох талаар мэдээлэл өгдөг бөгөөд мөн гарын авлага хэвлэн тараадаг.
- “МУИС-ийн индэр” хөтөлбөр, МУИС-ийн оюутны спортын их, бага наадам, NUM совет дууны тэмцээн, ЦЕГийн Хар тамхитай тэмцэх газраас сургалт, Тээврийн цагдаагийн газраас “Хичээх өдөр” үйл ажиллагаа, Авилгатай тэмцэх газраас “Үнэт зүйлсийн боловсрол” өдөрлөг, СБД-ийн Нийгмийн даатгалын хэлтэстэй хамтран оюутнуудыг эрүүл мэндийн даатгалд хамруулах үйл ажиллагаа, Цус сэлбэлтийн үндэсний төвтэй хамтран “Цусны донор” аян, жил бүрийн 12- сарын 01-нд ДОХ-той тэмцэх дэлхийн өдрийг МУИС-ийн “Залуучуудын улаан загалмай нийгэмлэг”, Оюутан төгсөгчийн хэлтэстэй хамтран тус тус зохион байгуулдаг.
- Улсын хөдөлмөрийн төв бирж, Нийслэлийн хөдөлмөрийн газар, МУИС-ийн бүрэлдэхүүн сургуулиуд хамтран МУИС-ийн төгсөгчдийг ажлын байртай болгох, ажил олгогч аж ахуйн нэгж байгууллагуудад МУИС-ийн төгсөгчдөөс хүний нөөцөө бүрдүүлэхэд нь дэмжлэг үзүүлэх, оюутнуудын байнгын болон зуны амралтаар

хөдөлмөр эрхлэх боломжийг нэмэгдүүлэх зорилгоор “CAREER & JOB FAIR” өдөрлөгийг төлөвлөгөөний дагуу жил бүр зохион байгуулдаг уламжлалтай.

- Монголын томоохон аж ахуй нэгж болох Таван богд групп, Витафит групп “Гоё” тарагны үйлдвэртэй танилцах аялал, МУИС, Бизнетворк ХХК, хамтран “Орлоготой оюутан” хөтөлбөрийн хүрээнд “Түр ажлын байрны өдөрлөг” тус тус зохион байгуулдаг.

Шалгуурыг хангасан байдал: Бүрэн хангасан.

Анхаарах асуудал:

- Суралцахуйн үйлийг дэмжих, зөвлөхдөө хөдөлмөрийн зах зээлийн эрэлт хэрэгцээ, тухайн оюутны нөхцөл байдалд үнэлгээ хийх.

Зөвлөмж:

- 1-р түвшний оюутнуудад Ойн аж ахуй хөтөлбөрийг сурталчлан таниулах

5.3. Суралцагчийн олон нийтийн оролцоо, урамшуулал

Суралцагчийн олон нийтийн үйл ажиллагаанд оролцох оролцоо, сайн дурын ажлыг дэмжиж хамтран ажилладаг байна.

Илрэл нотолгоо:

- МУИС-ийн багш нар оюутан суралцагчдын судалгаа, шинжилгээний ажлыг удирдан зохион байгуулж ажилладаг.
- МУИС-ийн хэмжээнд Оюутан, төгсөгчийн хэлтэс зохион байгуулан олон төрлийн клубүүд үйл ажиллагаа явуулдаг.
- МУИС-ийн захирлын 2019 оны 12-р сарын 31-ний өдрийн А/571 тушаалаар шинэчлэн баталсан “МУИС-д суралцагчдад тэтгэлэг олгох нийтлэг журам”-аар зохицуулдаг. Мөн суралцагчид дотоодын төдийгүй гадаадын төрийн болон хувийн байгууллага, сан, хувь хүний нэрэмжит тэтгэлэг, урамшуулал, хөнгөлөлтүүдэд хамрагдах бүрэн боломжтой.
- Оюутны эрдэм шинжилгээний хурал
- Олон улсын Ойн өдрөөр зохион байгуулдаг Монгол Улсын Их дээд сургуулиудын дунд зохион байгуулдаг Оройн нахиа эрдэм шинжилгээний хурал, олимпиадууд
- Багшийг дагалдан судалгааны ажлын арга барилд суралцах, профессор багшийн судалгааны семинарт оролцох, илтгэл тавих
- Залуучуудын улаан загалмай, INTRO англи хэлний, Undergraduate Women in Business Mongolia клуб, HACKUM клуб, Илтгэл, парламентын мэтгэлцээний “Өөрчлөлт” клуб, Best” клуб /илтгэх урлаг, парламентийн мэтгэлцээний чиглэлээр сургалт явуулдаг, Монголын Соёлын Байгууллага” (МСО) клуб, “Лука” клуб /Орос хэл болон Хүмүүнлэгийн гэсэн хоёр чиглэлтэй, “Билим” клуб, “Залуу Социологич” клуб, БСОН Бизнесийн Сургуулийн Оюутны Нэгдэл Клуб, ХОС УЯНГА Монгол бичиг соёлын клуб, Экологи клуб, “Unity of Scienc” судалгаа, мэтгэлцээний клуб, “Номтой найзалъя” клубууд үйл ажиллагаа явуулдаг.

- Монголын Ой судлаач оюутан залуучуудын холбоо - Монгол орны ойн салбарт тулгамдсан асуудлыг шийдвэрлэхэд оролцох, оюутнуудын мэргэжлийн мэдлэг чадварыг дээшлүүлэх, эрдэм шинжилгээний ажилд сонирхолтой болгох, төгсөгчдийг мэргэжлийн ажилд зуучлах, гадаадын ижил төстэй байгууллагуудтай холбоо тогтоон хамтран ажиллаж байна.
- Тэтгэлэг, урамшуулал, хөнгөлөлтийн зарыг холбогдох шалгуурын хамт МУИС-ийн вэб хуудас болон Оюутан, төгсөгчийн хэлтсийн вэб хуудас дээр мэдээлэх замаар МУИС-ийн нэрэмжит тэтгэлэг, МУИС-ийн шинэ элсэгчийн тэтгэлэг, Монгол судлалыг дэмжих тэтгэлэг, Япон улсын “Сумитомо” корпорацийн нэрэмжит тэтгэлэг, Япон улсын “Мицубиши” корпорацийн нэрэмжит тэтгэлэг, Япон улсын “Мицубиши UFJ” сангийн нэрэмжит тэтгэлэг, БНСУ-ын “POSCO ASIA FELLOWSHIP”-ийн тэтгэлэг, БНСУ-ын “Намъянжу” боловсролыг дэмжих сангийн тэтгэлэг, БНСУ-ын “Дун-Ин форум”-ын нэрэмжит тэтгэлэгт хөтөлбөр 10. БНСУ-ын ОК BAE&JUNG нэрэмжит тэтгэлэг, Тайванийн иргэн Өнө Уртагийн нэрэмжит тэтгэлэг, Тайванийн Монгол-Төвдийн хорооны тэтгэлэг, Күнзийн институтын оролцоотой тэтгэлэг, Оюутан солилцооны тэтгэлэгт хөтөлбөрүүд, Элсэгчдийг дэмжих тэтгэлэгт шалгаруулан оюутнуудад олгодог байна.

Шалгуурыг хангасан байдал: Бүрэн хангасан.

- **Анхаарах асуудал:**

Суралцагчдын олон нийтийн үйл ажиллагаанд хамруулах, татан оролцуулах.

5.4. Суралцагчийн шилжилт, хөдөлгөөн

Суралцагчийн шилжилт хөдөлгөөнийг шийдвэрлэхдээ /кредитийг хүлээн зөвшөөрөх, дүйцүүлэн тооцох, кредитээс чөлөөлөх/ холбогдох дүрэм, журмын дагуу суралцагчийн эрх ашигт нь нийцүүлэн шийдвэрлэдэг байна.

Илрэл нотолгоо:

- МУИС-ийн захирлын 2019 оны 11-р сарын 14-ний өдрийн А/483 тоот тушаалаар “МУИС-д суралцагч шилжүүлэн суралцуулах журам”
- МУИС-ийн захирлын 2019 оны 11-р сарын 18-ны өдрийн А/495 тоот тушаалаар “МУИС-д хичээл дүйцүүлэх журам”

Анхаарах асуудал:

- Оюутан суралцагчдыг бие даан суралцах арга барилыг сайжруулахад чиглэсэн үйл ажиллагаа явуулах.
- Идэвхгүй (бүртгэлтэй боловч тодорхойгүй шалтгаанаар суралцдаггүй) суралцаж буй суралцагчдын тоо бууруулах.

Зөвлөмж:

- Сургалтын албатай хамтран оюутны шилжилт хөдөлгөөн болон хичээл завсардалтын шалтгаанд дүн шинжилгээ дүгнэлт хийх

Шалгуурыг хангасан байдал: Бүрэн хангасан.

Онцлог зүйл/Туршлага:

- Шилжилт хөдөлгөөнийг хичээлийн жилд 2 удаа зохион байгуулах бөгөөд шилжилтийн бүртгэлийг намрын улиралд 7-р сарын 01-ээс 8-р сарын 15, хаврын улиралд 12-р сарын 15-аас 01-р сарын 15-ыг дуустал <https://burtgel.num.edu.mn> бүртгэлийн нэгдсэн системээр бүртгэдэг.

5.5. Төгсөлтийн баримт бичиг

Төгсөлтийн баримт бичиг нь оюутны мэргэшил, хувь хүний гүйцэтгэл, хөтөлбөрийн үр дүн, эзэмшсэн агуулга, түвшин зэргийг тусгасан байна.

Илрэл нотолгоо:

- МУИС-ийн захирлын захирлын 2015 оны 6-р сарын 30-ны өдрийн А/203 тоот тушаалаар батлагдсан Сургалтын журмын 4.12.4-т заалт

Шалгуурыг хангасан байдал: Бүрэн хангасан.

Онцлог зүйл/Туршлага:

- Төгсөлтийн салбар комисс сургуулийн архивт төгсөгчтэй холбоотой төгсөлтийн салбар комиссын хурлын шийдвэр, диплом олгосон бүртгэлийн хуулбар, хамгаалуулах зөвлөлийн хуралдааны протокол, тогтоол, удирдагчийн тодорхойлолт, суралцсан хугацааны тодорхойлолт, дипломын хуулбар, сурлагын дүнгийн эх хувь нэг, дэлгэрэнгүй анкет, суралцагчийн үнэмлэх болон тойрох хуудас зэрэг баримт бичгүүдийг бүрдүүлж өгдөг.

Анхаарах асуудал:

- Бакалаврын 4 болон 5 дугаар түвшинд суралцаж буй суралцагчдын тооны бууралттай холбоотойгоор төгсөлт багассан.
- Төгсөх хүсэлт гаргасан нийт оюутнуудын 18.3 хувь нь төгсөөгүй.
- Төгсөлт хойшилсон оюутнуудын дийлэнх хувь нь хичээл, дадлага, нэгдсэн шалгалтандаа хангалтгүй үнэлгээ авсан байна.

Зөвлөмж:

- Төгсөх хүсэлт гаргасан нийт суралцагчдыг хоцрогдолгүй төгсгөх боломжийг эрэлхийлэх.

5-р шалгуурын талаарх шинжээчийн эцсийн үнэлгээ: БҮРЭН ХАНГАСАН.

Шалгуур 6. Багшлах бүрэлдэхүүн

Багшийн үйл ажиллагаа нь хөтөлбөрийн үр дүнг амжилттай хэрэгжүүлж, хөгжүүлэхэд чиглэсэн байна.

6.1. Багшийн сонгон шалгаруулалт, зэрэглэл, урамшууллын бодлого

Хөтөлбөр нь тавьсан зорилго, зорилтоо хангахуйц онол дадлагыг зохистой хэмжээнд эзэмшсэн эрдмийн зэрэг цолтой, сургалтын арга зүйн өндөр ур чадвартай, мэргэжлийн туршлага бүхий багшийн нөөцтэй байна.

Илрэл нотолгоо:

- Хөдөлмөрийн тухай хууль
- МУИС-ийн Хөдөлмөрийн дотоод журам
- МУИС-д зөвлөх, гэрээт ба зочин профессор, цагийн багш ажиллуулах журам
- МУИС-д профессор, багш ажиллуулах журам
- МУИС-ийн багш, ажилтан, суралцагчийн ёс зүйн дүрэм
- Ойн аж ахуйн хөтөлбөрийн багш нар 100% нь гадаад болон дотоодод докторын зэрэг хамгаалсан, Профессор-2, Дэд профессор-2, багш нарын олонх нь мэргэжлээрээ 15-аас дээш жил ажилласан дадлага, туршлагатай.
- Эрдэм шинжилгээний бүтээлээрээ тухайн салбартаа олон улсын хэмжээнд өндрөөр үнэлэгдсэн эрдэмтнийг сонгон шалгаруулалтгүйгээр дэд профессор, профессорын зэрэглэлд ажиллуулах.
- 5 жилд гүйцэтгэсэн эрдэм шинжилгээний ажлын үзүүлэлтийг гол шалгуур болгон хичээлийн жилийн эцэст дараагийн 3 жилд ажиллах багш нарын албан тушаалын зэрэглэлийг тогтоодог.
- МУИС нь Сургалтын ажлын хүрээнд, Судалгааны ажлын хүрээнд, Нийгэмд үйлчлэх хүрээнд, Суралцагчтай харилцах, Хамт олонтой харилцах хүрээнд харилцааны ёс суртахууны, үүрэг болгосон, хориглосон зэрэг мэргэжлийн ёс суртахууны хэм хэмжээг дагаж мөрдөхийг давхар шаардан ажилладаг.
- Хамт олноо манлайлан, их сургууль болон шинжлэх ухаан, технологи, боловсролын салбарыг хөгжүүлэх үйлсэд идэвхи санаачилга, үр бүтээлтэй ажиллаж, эрхэлж буй ажилдаа тодорхой амжилт гаргасан, ёс зүйн болон сахилгын зөрчилгүй багш, ажилтанг “МУИС-ын шагнал урамшууллын нийтлэг журам”-ын дагуу шагнаж урамшуулдаг.

Шалгуурыг хангасан байдал: Бүрэн хангасан.

Онцлог зүйл/Туршлага:

Анхаарах асуудал:

- Багшлах боловсон хүчний залгамж халааг бэлтгэх.

6.2. Багшийн хөгжил

Мэргэжлийн болон сургалт, эрдэм шинжилгээний мэдлэг, арга барил, ур чадвараа тасралтгүй хөгжүүлэхэд чиглэсэн багшийн хөгжлийн хөтөлбөртэй байна.

Илрэл нотолгоо:

- Монгол улсын их сургуулийн Стратегийн төлөвлөгөө (2016-2024)-ний алсын хараанд дэлхийн түвшний судалгааны их сургууль болно хэмээн тодорхойлоод “сургах ба сурах үйл явцыг дэлхийн тэргүүлэх түвшинд хүргэх”-д “багшлах шилдэг боловсон хүчнийг бүрдүүлж” ажиллах талаар стратегийн тэргүүлэх зорилтоо дэвшүүлсэн.
- МУИС-ийн захирлын 2019 оны 02-р сарын 04-ний өдрийн А/52 тоот тушаал “МУИС-ийн Багшийн хөгжлийн хөтөлбөр” (2019- 2024) бодлогын баримт бичиг

Шалгуурыг хангасан байдал: Бүрэн хангасан.

Онцлог зүйл/Туршлага:

- Багшийн мэргэжил, заах арга зүйн ур чадвар, эрдэм шинжилгээ, судалгааны арга зүйн түвшин, суралцах хэрэгцээг тодорхойлох дараах судалгааг тогтмол хийдэг.
- Багшийн хөгжил, цахим сургалтын төв нь дараах сургалт, хөтөлбөрүүдийг жил бүр тогтмол зохион байгуулдаг. Үүнд: Шинэ багшийн чиглүүлэх сургалт /New Faculty Orientation/, “Faculty Writing Retreats” хөтөлбөр, Effective teaching in higher education program, “Залуу эрдэмтдийн индэр - NUM speaker series.

Анхаарах асуудал:

- Орчин үеийн шаардлага хангасан сургалтын хөтөлбөрөөр багшийн хөгжлийг дэмжих үе шаттай бодлого хэрэгжүүлэх
- Өндөр технологи бүхий лабораторид ажиллах хүний нөөц дутмаг

Зөвлөмж:

- Салбар сургуулийн багш нарыг мэргэжлийн хувьд чадавхжуулах чиглэлээр гадаадад суралцуулахад дэмжлэг үзүүлэх

6.3. Эрдэм шинжилгээ, судалгаа

Багш эрдэм шинжилгээ, судалгааны ажлыг тогтмол хийж, судалгааны үр дүн нь хөтөлбөр хэрэгжүүлэхэд үр нөлөөтэй байна.

Илрэл нотолгоо:

- МУИС нь 2016-2024 оны стратегийн төлөвлөгөөндөө судалгааны хамрах хүрээг өргөжүүлэх, судалгааны түвшинг дэлхийн жишигт нийцүүлэхээр тэргүүлэх чиглэлээ тодорхойлж, судлаач багш нарын судалгааны үйл ажиллагааг дэмжих, эрдэм шинжилгээний бүтээлийн түвшин, эрдэм шинжилгээний гадаад дотоод хамтын ажиллагааг нэмэгдүүлэх зорилгоор “МУИС-ийн судалгааны санхүүжилтийн журам” батлан хэрэгжүүлж байна.

Шалгуурыг хангасан байдал: Бүрэн хангасан.

Онцлог зүйл/Туршлага:

- Сүүлийн 5 жилд ШУТС, үйлдвэр аж ахуйн нэгж болон бусад эх үүсвэрээс 1,369,516.3 төгрөгний санхүүжилттэй төсөл, гэрээт судалгаа 39 хэрэгжүүлсэн байна.
- Web of Science Өгүүллийн тоо 43 өгүүлэл, Scopus Өгүүлэл 14 ийг бичиж хэвлүүлжээ.

Анхаарах асуудал:

- Судалгааны их сургууль болох зорилтын хүрээнд үе шаттай төлөвлөгөө гаргаж ажиллах

Зөвлөмж:

- Судалгааны ажилд тодорхой хөрөнгө төсөвлөж багш, судлаач оюутнуудыг хамруулах

6.4. Багшийн үнэлгээ

Багшийн сургалт, заах арга зүй, эрдэм шинжилгээ, судалгаа, мэргэжлийн болон нийгмийн үйлчилгээний /зөвлөх үйлчилгээ/ чиглэлээр хичээлийн жил тутам өөрийн болон хөндлөнгийн үнэлгээг тогтмол гүйцэтгэж, үр дүнг тооцдог байна.

Илрэл нотолгоо:

- Хичээлийн жилийн төгсгөлд багш нарын сургалтын ажлын гүйцэтгэлийг тэнхимийн эрхлэгч тооцож сургалт хариуцсан нэгж хянах ба багш нарын жилийн нийт А, Б, В цагийн гүйцэтгэлийг бүрэлдэхүүн, салбар сургуулийн захирал хянаж баталгаажуулдаг.

Шалгуурыг хангасан байдал: Бүрэн хангасан.

Онцлог зүйл/Туршлага:

- МУИС-ийн Хөдөлмөрийн дотоод журам болон бусад урамшууллын системээр багш нарын илүү цагийн хөлс олгох, оны шилдэг бүтээлийг шалгаруулах, эрдэм шинжилгээ, инновацыг дэмжих, судалгааны төслийн грант олгох, докторын сургалтанд хамрагдсан багш нарт хөнгөлөлт, урамшуулал олгох зэрэг урамшуулалын тогтолцоо хэрэгжиж байна.

Анхаарах асуудал:

- Багшийн ажиллах идэвхийг нэмэгдүүлэх, багшийн үнэлгээг тогтмол зөв шударга үнэлэх.

Зөвлөмж:

6-р шалгуурын талаарх шинжээчийн эцсийн үнэлгээ: БҮРЭН ХАНГАСАН.

Шалгуур 7. Чанарын үнэлгээ, баталгаажилт

Хөтөлбөрийг тасралтгүй хөгжүүлэхэд чиглэгдсэн дотоод чанарын баталгаажуулалтын механизмтай, хөндлөнгөөс үнэлүүлдэг байна.

7.1. Хөтөлбөрийн чанарын дотоод баталгаажуулалт, сайжруулалт

Хөтөлбөрийг оролцогч талуудын оролцоотойгоор тасралтгүй хөгжүүлэхэд чиглэсэн үечилсэн чанарын дотоод болон хөндлөнгийн баталгаажуулалтын механизмтай байна.

Илрэл нотолгоо:

- МУИС нь 2017 оны 10-р сарын 13-ны өдөр Захирлын Б/500 тушаалаар Хөтөлбөр, чанарын баталгаажуулалтын алба гэсэн нэгж (бүтэц)-ийг сургалтын нэгдсэн газрын дор байгуулагдаж 10 хүний бүрэлдэхүүнтэй үйл ажиллагаагаа нь явагдаж байна.
- Тус алба нь Сургалтын нэгдсэн газар татан буугдсантай холбоотойгоор 2018 оноос Хөтөлбөр, чанарын баталгаажуулалтын хэлтэс (ХЧБХ) нэртэйгээр үйл ажиллагаагаа явуулж байна. оноос чанарын удирдлага зохицуулалтын албыг байгуулан хүний нөөц, хяналтын шинжилгээ, гадаад харилцаа, хэвлэл мэдээлэл гэсэн бүрэлдэхүүнтэйгээр үйл ажиллагаагаа явуулж байна.

- Тус хэлтэс нь хөтөлбөрийн шинэчилсэн журам боловсруулах болон хөтөлбөрийн чанарын үнэлгээний үзүүлэлтүүд, гүйцэтгэх нэгдсэн аргачлал, шийдвэрлэх арга зам зэргийг тодорхойлсон байна.

Шалгуурыг хангасан байдал: Бүрэн хангасан.

Онцлог зүйл/Туршлага:

- Сургалтын нэгдсэн газар татан буугдсантай холбоотойгоор 2018 оноос Хөтөлбөр, чанарын баталгаажуулалтын хэлтэс (ХЧБХ) нэртэйгээр үйл ажиллагаагаа явуулж байна.

Анхаарах асуудал:

- Хөтөлбөрийн дотоод чанарын баталгаажуулалтыг хийхдээ оролцогч талуудыг татан оролцуулахаар төлөвлөж, суралцагсад, төгсөгч, ажил олгогчийн төлөөллийн санал бодлыг тусгах тал дээр анхаарч ажиллах.

Зөвлөмж:

- Хөтөлбөрийн чанарын баталгаажуулалтын хэлтэс нь бакалаврын сургалтын заах арга, үнэлгээнд хяналт тавих ажиллагааг зохион байгуулах.
- Дотоодын хөндлөнгийн хяналт, үнэлгээг журмаар зохицуулах.

7.2. Хөтөлбөрийн үр дүн

Хөтөлбөрөөр төгсөгч нь сонирхогч талуудын эрэлт хэрэгцээг хангасан, улс орны болон салбарын ирээдүйн тогтвортой хөгжилд хувь нэмрээ оруулан сэтгэл ханамжтай ажиллаж, амьдрах цогц чадамжтай байна..

Илрэл нотолгоо:

- Төгсөгчдийн ажил эрхлэлтийн судалгаанаас үзэхэд, мэргэжлээрээ ажиллаж байгаа 25 (17.3%) төгсөгч, 14 (9.7%) төгсөгч дараагийн шатанд суралцаж байгаа ба үлдсэн 119 (73%) төгсөгч мэргэжлийн бус, хувиараа, ажил эрхлээгүй байгаа нь судалгааны үр дүнгээр илэрсэн байна.
- 2014-2019 оны улирал тус бүрээр авч үзвэл, хөтөлбөрийн нийт 6 багшийн дунджаар тооцоход багшийн талаар 2.41, сургалтын орчны талаар 2.35, хичээлийн талаар 2.36 байсан бол нийт дундаж үнэлгээ 2.37 байна.

Шалгуурыг хангасан байдал: Бүрэн хангасан.

Онцлог зүйл/Туршлага:

Анхаарах асуудал:

- Төгсөгчдийг давтан сургах мэдлэг, ур чадварыг нэмэгдүүлэх дээшлүүлэхэд анхаарах.

Зөвлөмж:

- Ажил олгогч төгсөгчдийн эргэх холбоог сайжруулах, тогтмол ажиллуулах.
- Төгсөгчдийн холбооны үйл ажиллагааны маркетинг идэвхжүүлж, сургалтын хөтөлбөрийн сайжруулалтад тэдний саналыг тусгах.

7.3. Үндэсний болон олон улсын хэмжээнд хүлээн зөвшөөрөгдөх

Үндэсний болон олон улсын хэмжээнд хөндлөнгийн үнэлгээ, магадлан итгэмжлэл хийлгэн суралцагчдын цогц чадамжийг хүлээн зөвшөөрүүлж, олон улсын түвшинд суралцах боломжийг нэмэгдүүлдэг байна.

Илрэл нотолгоо:

- МУИС нь БМИУЗ-ийн удирдах зөвлөлийн 2018.06.26-ны өдрийн 29 тоот тогтоолоор 5 жилийн хугацаатай магадлан итгэмжлэгдсэн.
- 2000 оны үеэс салбарын судлаачид гадаад, дотоодын их, дээд сургуулиудад докторын зэргийг олноор хамгаалж эхэлсэн бөгөөд 2000 оноос ойн чиглэлээр 31 судлаач докторын зэрэг хамгаалсны 14 нь МУИС-ийн ОАА хөтөлбөрийн бакалаврын төгсөгчид байна. Эдгээр 14 доктороос 10 нь ХБНГУ, БНСУ, ОХУ, БНЧУ, АНУ, Япон, Тайвань зэрэг орны дэлхийн нэр хүндтэй их сургуулиудад докторын зэрэг хамгаалсан.

Шалгуурыг хангасан байдал: Бүрэн хангасан.

Онцлог зүйл/Туршлага:

- ОАА хөтөлбөр нь сургалтын хөтөлбөрөө амжилттай хэрэгжүүлэхийн тулд багш, суралцагчид ашиглах мэдээ, мэдээллийн эх сурвалжийг өргөтгөх, чанаржуулах, мэргэжлийн ур чадвараа хөгжүүлэх орчин нөхцлөөр хангах чиглэлээр тодорхой ажлуудыг хэрэгжүүлэн ажиллаж байна.
- Багш, судлаачид, магистрант, докторантуудын эрдэм шинжилгээ, судалгааны ажлыг үр дүнтэй, чанартай явуулахын тулд олон улсад хүлээн зөвшөөрөгдсөн эрдэм шинжилгээний өгүүлэл татах, системд хандах эрхийг нь авч ашиглах боломжийг бүрдүүлээд байна. Үүнд: - Springer link - <https://link.springer.com/>.
- Ebsco - <https://www.ebsco.com/who-we-serve/academic-libraries> зэрэг сангууд орно.
- Хөтөлбөрийн багш нарын хэрэгжүүлдэг эрдэм шинжилгээний төсөл, хөтөлбөрт судлаач оюутнаар хамруулж, суралцагчдын сурах хүсэл эрмэлзлийг нэмэгдүүлж, 169 идэвх, санаачлагатай зарим оюутнуудын сургалтын төлбөрт санхүүгийн дэмжлэг үзүүлэн ажиллаж байна.

Анхаарах асуудал:

- Чанарын баталгаажуулалтанд хөтөлбөрийн оролцогч болон сонирхогч талуудын оролцоог тодорхой болгох.

Зөвлөмж:

- Төгсөгчдийн мөшгих судалгааг үе шаттай зохион байгуулах.

7-р шалгуурын талаарх шинжээчийн багийн эцсийн үнэлгээ: БҮРЭН ХАНГАСАН.

ДҮГНЭЛТ

Шалгуур		Бүрэн хангасан (2)	Хэсэгчлэн хангасан (1)	Хангааг үй (0)	Үндэслэл, шалтгаан
1		2			
2		2			
3		2			
4		2			
5		2			
6		2			
7		2			
Дүгнэлт		Бүрэн хангасан.			


Баримт материал, нотлох баримт, уулзалт ярилцлага дээр үндэслэн шинжээчийн баг Монгол Улсын Их Сургуулийн Хэрэглээний шинжлэх ухаан инженерчлэлийн сургуулийн “Ой аж ахуй” хөтөлбөрийг БМИҮЗ-ийн сургалтын хөтөлбөрийн магадлан итгэмжлэлийн ерөнхий шалгуур шаардлагад нийцэж байгаа тул “ШАЛГУУРЫГ БҮРЭН ХАНГАСАН” гэж дүгнэж байна.

Шинжээчийн багийн дүгнэлтийг ХӨДӨӨ АЖ АХУЙ, ОЙ, ЗАГАСНЫ АЖ АХУЙН чиглэлээр хөтөлбөрийн үнэлгээ хийх мэргэжлийн зөвлөлд хүргүүлж байна.


Шинжээчийн багийн ахлагч: Д.Хандсүрэн



Шинжээчийн багийн гишүүн: О.Энхтуяа



Шинжээчийн багийн гишүүн: Я.Гэрэлчулуун



НЭГДСЭН ЗӨВЛӨМЖ

Сургуулийн нэр	МУИС, Хэрэглээний шинжлэх ухаан инженерчлэлийн сургууль
Хөтөлбөрийн нэр	“Ойн аж ахуй” бакалаврын хөтөлбөр
Хөтөлбөрийн индекс	D082101
ЗӨВЛӨМЖ	
Шалгуур 1. Хөтөлбөрийн төлөвлөлт	<ul style="list-style-type: none"> ✓ Ойн аж ахуй сургалтын хөтөлбөрийн хүрээнд төрийн ба төрийн бус байгууллагууд, аж ахуй нэгжүүдэд 7, 10 хоногоор сургалт, үйлдвэрлэлийн дадлагыг хийлгэж, суралцагчдын чадамжийг нэмэгдүүлэх. ✓ Зах зээлийн эрэлт хэрэгцээнд нийцүүлэн төгсөгчид, ажил олгогчдоос давтамжтай судалгаа авч, хөтөлбөрийн агуулгыг үе шаттайгаар шинэчлэх сайжруулах. ✓ Хөтөлбөр нь оюутны бие даан суралцах, асуудал дэвшүүлэх, асуудалд дүн шинжилгээ хийх (<i>critical thinking</i>), орчин үеийн мэдээллийн технологийг ашиглан мэдлэг эзэмших, бүтээлчээр тасралтгүй бие даан суралцах үйл явцыг дэмжихэд туслах. ✓ Ойн аж ахуй салбарын хөдөлмөрийн зах зээлд эзлэх байр суурийг тодорхойлох, боломжийг судлан ажил олгогч, төгсөгчид, суралцагчдын саналыг төлөвлөгөөнд тусгаж, ажиллах.
Шалгуур 2. Сургалтын үйл ажиллагаа	<ul style="list-style-type: none"> ✓ Үр дүнд суурилсан сургалтад хөтөлбөрийн багш нарыг хамруулах, арга зүй эзэмшүүлэх, ур чадварыг дээшлүүлэхэд анхаарах. ✓ Боловсролын шинэчлэлтэй уялдуулан ойн аж ахуйн хөтөлбөрийг шинэчлэн сайжруулах.
Шалгуур 3. Хөтөлбөр хэрэгжүүлэх орчин, технологийн нөөц	<ul style="list-style-type: none"> ✓ Мэргэшүүлэх, мэргэжлийн хичээл заадаг багш нар ном, сурах бичиг гарын авлага туурвих.
Шалгуур 5. Суралцагчдад чиглэсэн үйлчилгээ	<ul style="list-style-type: none"> ✓ 1-р түвшний оюутнуудад “Ойн аж ахуй хөтөлбөр”-ийг сурталчлан таниулах, элсэгчдийн тоог нэмэгдүүлэх. ✓ Хөдөлмөрийн зах зээлийн эрэлт хэрэгцээнд тулгуурлан суралцагчдад зөвлөх туслах үйлчилгээ үзүүлэх.
Шалгуур 6. Багшийн үйл ажиллагаа	<ul style="list-style-type: none"> ✓ Багш нарыг мэргэжлийн хувьд чадавхжуулах чиглэлээр гадаадад суралцуулахад дэмжлэг үзүүлэх.
Шалгуур 7. Чанарын үнэлгээ, баталгаажилт	<ul style="list-style-type: none"> ✓ Хөтөлбөрийн чанарын баталгаажуулалтын хэлтэс нь бакалаврын сургалтын заах арга, үнэлгээнд хяналт тавих ажиллагааг зохион байгуулах. ✓ Дотоодын хөндлөнгийн хяналт, үнэлгээг журмаар зохицуулах. ✓ Ажил олгогч төгсөгчдийн эргэх холбоог сайжруулах, тогтмол ажиллуулах. ✓ Төгсөгчдийн холбооны үйл ажиллагааны маркетингийг идэвхжүүлж, сургалтын хөтөлбөрийн сайжруулалтад тэдний саналыг тусгах ✓ Төгсөгчид, ажил олгогчдын судалгааг үе шаттай зохион байгуулах.

IV. Ярилцлагад оролцогчдын нэрс

I. Багш нарын нэрс

№	Нэр	Албан тушаал	Зэрэг цол	Ажилласан жил	Заадаг хичээл
1	Н.Батхүү	Эрдэм шинжилгээ, хамтын ажиллагаа хариуцсан дэд захирал	Профессор	25	1. Модлог ургамлын анатоми, физиологи 2. Ойн селекц, генетик 3. Ой хамгаалал Хээрийн дадлага 2
2	Н.Баатарбилэг	Ахисан түвшний сургуулийн захирал	Профессор		1. Ойн экологи 2. Дендрохронологи Хээрийн дадлага 3
3	Б.Цэнгэл	Зөвлөх дэд профессор	Дэд проф.		Ой судлалын үндэс
4	Ц.Батчулуун	Дэд профессор	Дэд проф.		1. Инженерийн зураг зүй Ойн аж ахуйн тоног төхөөрөмж
5	С.Гэрэлбаатар	Дэд профессор	Дэд проф.		1. Ой зохион байгуулалт 2. Ойн зураг зүй 3. Ойн хөрс судлал 4. Ой зохион байгуулалт 5. Ойжуулалт, ойн мелораци 6. Хээрийн дадлага 1 Хээрийн дадлага 2
6	Б.Оюунсанаа	Дэд профессор	Доктор		1. Ой ба хүлэмжийн хий 2. Ойн загварчлал 3. Ойн таксац 4. Ойн түймрийн менежмент Хээрийн дадлага 3
7	С.Бямбагэрэл	Дадлагажигч багш	Магистр		1. Байгаль орчны индикатор ургамал судлал 2. Мод судлал 3. Ойн ГМС ба тандан судлал 4. Хот суурин цэцэрлэгжүүлэлт Хээрийн дадлага 1
8	Д.Мөнгөнцэцэг	Хичээлийн туслах ажилтан	Магистр		1. Хээрийн дадлага 1 2. Хээрийн дадлага 2 Хээрийн дадлага 3

9	Х.Билэгт	Техникч	Бакалавр	1	Ойн сургалт, судалгааны төвийг хариуцан ажилладаг
10	С.Чимэдцогзол	Англи хэлний багш	Магистр		Академик англи хэл- МУИС-ийн ерөнхий суурийн хичээл
11	Б.Оюунцэцэг	Биологийн хөтөлбөрийн багш	Дэд проф.		Ургамлын биологи – МУИС-ийн байгалийн ухааны ерөнхий суурийн хичээл
12	Б.Батсүрэн	Хүрээлэн буй орчин судлалын хөтөлбөр	Дэд проф.		Хүрээлэн буй орчин судлал – ХШУИС-ийн ерөнхий суурийн хичээл заадаг багш
13	Б.Ганбат	ХШУИС-ийн Электроникийн	Профессо р		Инженерийн физик - ХШУИС-ийн ерөнхий суурийн хичээл
14	С.Нарангарвуу	МУИС, БУС, Экологийн хөтөлбөрийн багш			Экологи - МУИС-ийн ерөнхий суурийн хичээл
15	Ц.Батчулуун	Дэд профессор	Дэд профессор		Инженерийн зураг зүй - ХШУИС-ийн ерөнхий суурийн хичээл

II. Оюутны нэрс

№	Оюутны нэрс	Курс	Сонгосон байдал
1	Р.Ган-Эрдэнэ	2-р түвшин	Улаанбаатар хот
2	О.Батзориг	1-р түвшин	Дархан уул аймаг
3	Ё.Гантөгс	4-р түвшин	Сайн дурын байгууллагын гишүүн
4	Б.Эрдэнэбат	4-р түвшин	Улаанбаатар хот
5	Э.Сондор	2-р түвшин	Улаанбаатар хот
6	Г.Содбаяр	3-р түвшин	Дотуур байр
7	М.Амартүвшин	2-р түвшин	Сэлэнгэ
8	С.Баттогтох	2-р түвшин	Дорноговь
9	Б.Однэмэх	3-р түвшин	Хэнтий
10	Л.Сарангуа	4-р түвшин	Дотуур байр

III. Ажил олгогчдын нэрс

№	Овог нэрс	Байгууллага	Албан тушаал
1	Б.Ганзориг	Ойн Судалгаа Хөгжлийн Төв, ОХМУГ Алба	Дарга
2	Э.Сансарбаяр	БОАЖЯ, ОБЗГ	Дарга
3	Ж.Түшигмаа	ШУА, Ботаникийн Ойн цэцэрлэгт хүрээлэн	Ойн фитоцинологийн лабораторийн эрхлэгч

4	Б.Удвал	ШУА, ГЗГЭ хүрээлэн	Ой нөөц, ой хамгааллын салбарын эрхлэгч
5	М.Чинсанаа	Нийслэл БОГ, Ойн хэлтэс	Дарга
6	Ч.Нямдаваа	Нийслэл МХГ	Дарга
7	Н.Өлзийбаяр	Тужийн нарсны БЦГ-н Хамгаалалтын Захиргаа	Дарга
8	Б.Оргилсайхан	Үндэсний цэцэрлэгт хүрээлэн	Ерөнхий инженер
9	Ц.Бямбасүрэн	Монголын цэцэрлэгжүүлэлтийн мэргэжлийн байгууллагуудын нэгдсэн холбоо ТББ	Тэргүүн
10	Д.Өлзийбаяр	Монголын байгаль орчны мэргэжилтнүүдийн холбоо ТББ	УЗ дарга
11	Б.Жавхлантагс	Гранд форст ХХК	Захирал
12	Д.Давааням	Мөнх ногоон тал ХХК	Захирал
13	Б.Энхтуяа	Увс аймаг БОГ	Дарга
14	С.Ганчимэг	ӨВ, Арвай хээр хот, ТГ	Дарга
15	Д.Туяа	Тарвагатайн нурууны байгалийн цогцолбор газрын хамгаалалтын захиргаа	Дарга

IV. Төгсөгчдийн нэрс

№	Овог нэрс	Төгссөн он	Байгууллага	Албан тушаал
1	Б.Бурмаа	2014	Өмнөговь Ойн анги	Дарга, магистрант
2	Б.Сэр-Оддамба	2010	БНСУ	Докторант
3	Д.Даваажав	2016	Япон	Докторант
4	Д. Хатанбаатар	2008	Австри улс	Докторант
5	Я.Ариунзул	1988	Эрдэнэт ТӨҮГ	Доктор
6	П.Баттулга	1998	Архангай	Сумын засаг дарга
7	С.Оюунтуяа	2009	Үндэсний цэцэрлэгт хүрээлэн	мэргэжилтэн
8	Ц.Хонгор	2002	НҮБ-ийн ХХАБ	Зөвлөх
9	Б.Тэмүүжин	2019	Ботаникийн хүрээлэн	ЭША
10	О.Лхагважаргал	2017	Дорноговь Замын-Үүд, НҮБ ХХААБ	Төслийн зохицуулагч
11	Э.Насанбаяр	2006	ОСХТөв	Ойн инженер
12	Д.Од	2009	Ногоон хэрэм	Ойн инженер
13	Г.Маралгоо	2015	БНСУ	Төслийн мэргэжилтэн
14	С.Золжаргал	2016	БНСУ	магистрант
15	У.Ганбат	2001	Грант Форест ХХК	инженер
16	С.Баршагуль	2013	Зүүнхараа Ойн анги	
17	Д.Жагдаг	1996	БОАЖЯ ОБЗГ	Ой хамгааллын мэргэжилтэн
18	Ш.Болорцэцэг	2009	Үндэсний цэцэрлэгт хүрээлэн	мэргэжилтэн

19	Батдорж	2008	Газар зүй, геоэкологийн хүрээлэн	Эрдэм шинжилгээний ажилтан
----	---------	------	----------------------------------	----------------------------

V. Хөтөлбөрийн өөрийн үнэлгээний багаас ирсэн санал
/албан бичгийг оруулах/



ҮІ. Мэргэжлийн зөвлөлийн шийдвэр

Мэргэжлийн зөвлөлийн хуралдаан (огноо) 2022.04.12

Мэргэжлийн зөвлөлийн хэлэлцүүлгийн дүгнэлт

Магадлан итгэмжлэх эсэх	Магадлан итгэмжлэл олгох хугацаа
Магадлан итгэмжилсэн	5 жил

ҮІІ. Магадлан итгэмжлэх комиссын шийдвэр

Магадлан итгэмжлэх комиссын хуралдаан (огноо) 2022.05.122

Магадлан итгэмжлэх комиссын хэлэлцүүлгийн дүгнэлт

Магадлан итгэмжлэх эсэх	Магадлан итгэмжлэл олгох хугацаа
Магадлан итгэмжилсэн	5 жил